МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 16
БҮРТГЭВ-03

simple | asset

# ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

**АНДЕРРАЙТЕР:** ULZII & Co CAPITAL, MANDAL CAPITAL

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



## АГУУЛГА

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ ........ 5
ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ........ 9
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ........ 10
ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ........ 12
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД ........ 13
НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН ........ 15
1.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ........ 16
1.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ........ 22
1.3 ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ ........ 24
ХОЁР. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ........ 25
2.1 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ ........ 26
2.2 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ........ 29
2.3 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ ........ 33
ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ........ 41
3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА ........ 42
3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ........ 43
3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН ........ 45
3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ ........ 46
3.5 ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ ........ 49
ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ........ 50
4.1 ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ ........ 51
4.2 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ ........ 53
4.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ ........ 55
4.4 ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ ........ 56
4.5 ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ ........ 57
4.6 ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ........ 62
4.7 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧЭЭС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ........ 63
4.8 ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ ........ 65
4.9 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА ........ 65

УЛААНБААТАР ХОТ
ЭДИЙН ЗАСГИЙН КО... ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН ..... 70
5.1 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ..... 71
5.2 ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ ЖУРМУУД ..... 73
ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА ..... 75
6.1 ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР ..... 76
6.2 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР ..... 77
6.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ ..... 77
6.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ ..... 78
6.5 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ..... 78
ДОЛОО. ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН ТУХАЙ ..... 82
7.1 АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ ..... 83
7.2 ХАМТРАГЧ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ ..... 85
7.3 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУХАЙ ..... 87
7.4 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 88
7.5 ХУУЛИЙН ДҮГНЭЛТ ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 89
НАЙМ. ХАВСРАЛТ ..... 92
8.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 93
8.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 95
8.3 ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН КОМПАНИЙН ДҮРЭМ ..... 96
8.4 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 102
8.5 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 104
8.6 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ ..... 108
8.7 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 109
8.8 ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ ..... 110
8.9 САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ..... 111
8.10 ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧИЙН ДҮГНЭЛТ ..... 112
8.11 ХУУЛИЙН ФИРМИЙН ДҮГНЭЛТ ..... 130

СЭХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



**ЗУРАГ**

Зураг 1. Эдийн засгийн бодит өсөлт ... 16
Зураг 2. Экспортын голлох бүтээгдэхүүн ... 17
Зураг 3. Төсвийн тэнцэл ... 18
Зураг 4. Инфляцын түвшин ... 19
Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт ... 20
Зураг 6. Төлбөрийн тэнцэл ... 21
Зураг 7. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ ... 22
Зураг 8. Хөрөнгийн биржийн индексүүд ... 23
Зураг 9. Хөрөнгийн зах зээлийн арилжааны дүн ... 23
Зураг 10. Гэрээт харилцагч, зээлдэгчийн тоо ... 29
Зураг 11. Хөрөнгийн бүтэц ... 34
Зураг 12. Зээлийн бүтэц ... 35
Зураг 13. Зээлийн үлдэгдэл ... 35
Зураг 14. Өр төлбөрийн бүтэц ... 36
Зураг 15. Өөрийн хөрөнгийн бүтэц ... 36
Зураг 16. Хүүгийн орлого ... 37
Зураг 17. Цэвэр ашиг ... 37
Зураг 18. Инфляц ба хадгаламжийн хүүний түвшин ... 53
Зураг 19. Системийн нөлөө бүхий топ-5 банкны хадгаламжийн хүү ... 54
Зураг 20. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны хүү ... 55

**ХҮСНЭГТ**

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл ... 17
Хүснэгт 2. Инфляцын төсөөлөл ... 19
Хүснэгт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл ... 26
Хүснэгт 4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтээгдэхүүний мэдээлэл ... 27
Хүснэгт 5. Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн байдлын тайлан ... 33
Хүснэгт 6. Ашид Капитал ББСБ ХХК-ийн орлогын тайлан ... 36
Хүснэгт 7. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд ... 38
Хүснэгт 8. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан байдал ... 39
Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл ... 42
Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс ... 45
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл ... 46
Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл ... 47
Хүснэгт 13. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал ... 47
Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл ... 48
Хүснэгт 15. Өгөөжийн тооцоолол ... 55
Хүснэгт 16. Төлбөрийн хуваарь ба аргачлал ... 56
Хүснэгт 17. Төлбөрийн график ... 57
Хүснэгт 18. Зээлийн багц, дүнгээр ... 60
Хүснэгт 19. Зээлийн багц, хугацаагаар ... 60
Хүснэгт 20. Зээлийн багц, улирлаар ... 61
Хүснэгт 21. Зээлийн багц, хүүний түвшнээр ... 61

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

СЭХ
2022 .06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

simple asset

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

# MCS ХОЛДИНГ ХХК
# ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 он 04 сар 06 өдөр — Дугаар 019 — Улаанбаатар хот

**Охин компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах тухай**

Ашид Капитал ББСБ ХХК-ийн Дүрмийн 6.1, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Дүрмийн 6.8.16, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашид Капитал ББСБ ХХК-ийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор 50,000,000,000 /Тавин тэрбум/ төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зэрэг шаардлагатай бусад байгууллагуудтай гэрээ байгуулах эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б. Тэмүүлэнд олгосугай.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор тусгай зориулалтын компани хэлбэрээр цаашид зохион байгуулагдах хязгаарлагдмал хариуцлагатай компанийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу байгуулах, Төлөөлөн удирдах зөвлөлийг томилох, холбогдох баримт бичигт төлөөлж гарын үсэг зурах эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б. Тэмүүлэнд олгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагад даалгасугай.

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА — Ж. ОДЖАРГАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот 14241, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла оффис, 24 давхар, Утас: 7777 8833
Э-шуудан: mcsgroup@mcs.mn, Вэб: www.mcs.mn

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК



MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
2022.06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-15
БҮРТГЭВ-03

simple asset

Ашид Капитал ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 он 03 сар 28 өдөр | Дугаар 05 | Улаанбаатар хот

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах тухай**

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дах заалт, 80-р зүйлийн 80.2 дэх заалт, Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор (50 тэрбум төгрөг хүртэлх) хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах зэрэг шаардлагатай бусад байгууллагуудтай гэрээ байгуулах эрхийг Компанийн гүйцэтгэх захирал (Б.Тэмүүлэн)-д олгосугай.
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор тусгай зориулалтын компани хэлбэрээр цаашид зохион байгуулагдах хязгаарлагдмал хариуцлагатай компанийг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Тэмүүлэн)-д даалгасугай.
3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны барьцаа болох зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хавсралтаар баталсугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Тэмүүлэн)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.БИЛИГҮҮН

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC

СЗХ
2022 .06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 16
БҮРТГЭВ-03



# СИМПЛ АССЕТ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 он 04 сар 13 өдөр Дугаар: 03 Улаанбаатар хот

**Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүний бэлтгэл ажлыг хангах тухай**

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 12 дугаар зүйлийн 12.2, Симпл Ассет ХХК-ийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.2.6.9-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Симпл Ассет ХХК нь 50,000,000,000 /тавин тэрбум/ төгрөг хүртэлх, нэг ширхэг нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, нийт 500,000 /таван зуун мянга/ ширхэг хүртэлх Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, нийтэд санал болохыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг тогтоолын 1 дүгээр хавсралтаар, Зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг 2 дугаар хавсралтаар, Тусгай зориулалтын компанийн дүрмийн төслийг 3 дугаар хавсралтаар, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг 4 дүгээр хавсралтаар, Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журмыг 5 дугаар хавсралтаар, Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журмыг 6 дугаар хавсралтаар, Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журмыг 7 дугаар хавсралтаар, Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журмыг 8 дугаар хавсралтаар, Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журмыг 9 дүгээр хавсралтаар, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг 10 дугаар хавсралтаар Санхүүгийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээний төслийг 11 дүгээр хавсралтаар, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний төслийг 12 дугаар хавсралтаар, Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний төслийг 13 дугаар хавсралтаар, Хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээний төслийг 14 дүгээр хавсралтаар, Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төслийг 15 дугаар хавсралтаар, Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээний төслийг 16 дугаар хавсралтаар, Хуулийн хөндлөнгийн шинжээчтэй байгуулах гэрээний төслийг 17 дугаар хавсралтаар, Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээний төслийг 18 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахтай холбоотойгоор Хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх этгээдээр

УЛААНБААТАР ХОТ
ЭЛЗИЙ ЭНД КО
5183855
9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
АТА7942 6052688
9002040547



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022 .06сар 8 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-15
БҮРТГЭВ-03

simple asset

"Өмгөөллийн Батбаяр энд Партнерс" ХХН-ийг, Санхүүгийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх этгээдээр "Шонхор Аудит Үнэлгээ" ХХК-ийг, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон Хэлцлийн зөвлөхөөр "Юнайтед Айр Файнэнс" ХХК-ийг, Үндсэн андеррайтераар "Өлзий энд Ко ҮЦК" ХХК-ийг, хамтрагч андеррайтераар "Мандал Капитал Маркетс ҮЦК" ХХК-ийг, Хөндлөнгийн аудиторын үйлчилгээ үзүүлэх этгээдээр "Шонхор Аудит Үнэлгээ" ХХК-ийг, Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх этгээдээр "Ашид Капитал ББСБ" ХХК-ийг тус тус сонгосугай.

4. Тогтоолын 1 дэх заалттай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авах, үнэт цаасыг бүртгүүлэхтэй холбоотой Санхүүгийн зохицуулах хороонд хүсэлт гаргах, холбогдох өргөдөл, баримт бичиг, материалыг бүрдүүлэн өгөх, гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Н.Эрдэнэхүүд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА [signature] Д.БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ
ХХК

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
КАПИТАЛ ҮЦК
ХХК
5183855
9021031195 СТС2420

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ
ХХК

MANDAL CAPITAL
MARKETS

СЗХ
2022 .06 .08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 16
БҮРТГЭВ-03

simple asset

## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмуудын дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 500,000 ширхэг үнэт цаасыг нийтэд нээлттэй арилжихтай холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно.

Үнэт цаас гаргагч Симпл Ассет ТЗК ХХК нь энэхүү 50,000,000,000 төгрөгийн үнэт цаасыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК-аас зээлийн багц шилжүүлэн авахад ашиглах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэхэд зарцуулна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Мөн Санхүүгийн Зохицуулах Хороо үнэт цаасыг бүртгэсэн нь уг үнэт цаас болон түүнийг баталгаажуулж буй зээлийн багц дахь мэдээлэл, хөдлөх хөрөнгийн үнэлгээ болон холбогдох бусад мэдээлэл нь үнэн зөв, эрсдэлгүй гэсэн баталгаа биш бөгөөд үнэт цаасанд эрсдэл үүсвэл Санхүүгийн Зохицуулах Хороо хариуцахгүй болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэл, хөндлөнгийн шинжилгээний дүгнэлтэд үндэслэн боловсруулсан бөгөөд мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ АЛИВАА ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ БАТАЛГАА БИШ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ ГЭДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ТУХАЙН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ЗАХ ЗЭЭЛД ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛЖ ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч Симпл ассет ТЗК ХХК болон Андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК, Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК
5183855

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ТЗК ХХК
9022060074

MANDAL CAPITAL MARKETS LLC

# НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| **Анхдагч зах зээл** | Анх удаа олон нийтэд үнэт цаасыг худалдаж буй үйл ажиллагаа |
| **Анхны үүрэг гүйцэтгүүлэгч** | Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд буюу Ашид Капитал ББСБ ХХК |
| **Баталгаат үнэт цаас** | Үнэт цаас гаргагчийн арилжаалах Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаас |
| **Бирж** | Монголын Хөрөнгийн Бирж |
| **Дижитал зээл** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гэрээт харилцагчид зээлийн эрхийн хүрээнд аппликейшнээр олгож буй зээл |
| **Зээлдэгч** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн холбогдох журамд заасан шалгуурыг хангаж дижитал зээл авсан этгээд |
| **Зээлийн баримт бичгүүд** | ББСБ-аас зээлдэгчид зээл олгосон Хэрэглээний зээлийн эрхийн гэрээ болон цахим зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, бусад баримт бичгүүд |
| **Зээлийн гэрээ** | Зээлдэгч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээ |
| **Зээлийн дансны бүртгэл** | Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацаатай нь бүртгэсэн мэдээлэл |
| **Зээлийн эргэн төлөлт** | Зээлдэгчийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх зээлийн үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүү |
| **Төлбөр цуглуулах данс** | Зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг хүлээн авах зорилгоор банканд тусгайлан нээсэн тусгай зориулалтын компанийн данс; |
| **Үйлчилгээ үзүүлэгч** | Үнэт цаас гаргагчтай байгуулсан үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд зээлийн эргэн төлөлттэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэх үйлчилгээг үзүүлж буй этгээд |
| **Үнэт цаас гаргагч** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож буй тусгай зориулалтын компани буюу Симпл Ассет ТЗК ХХК |
| **Үнэт цаас эзэмшигч** | ТЗК-ийн гаргасан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авч, эзэмшиж буй этгээд |

| | |
|---|---|
| **Үнэт цаасны төлбөр** | Энэхүү үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаасны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр |
| **ҮЦТХТ** | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| **ҮЦТ** | Энэхүү үнэт цаасны танилцуулга |
| **Хороо эсхүл СЗХ** | Санхүүгийн зохицуулах хороо |
| **Хөрөнгийн багц эсхүл багц** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хооронд "Хөрөнгө худалдах, худалдаж авах" гэрээний 1 дүгээр зүйлд тодорхойлогдсон, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан хөрөнгүүд |
| **Хөрөнгийн багцын эсхүл багцын эргэн төлөлт** | Сар тутам Үйлчилгээ үзүүлэгч нь Төлбөр цуглуулах данснаас Үнэт цаас гаргагчийн Төлбөр гүйцэтгэх дансанд шилжүүлж буй Зээлийн эргэн төлөлтийн нийлбэр дүн |
| **Хөрөнгийн жагсаалт** | Үнэт цаасны танилцуулга, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах, худалдаж авах гэрээ"-нд хавсаргасан хөрөнгийн жагсаалт |
| **Хөрөнгө** | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3.1.1-д заасан үнэт цаасыг баталгаажуулж буй зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх |
| **Хөрөнгө итгэмжлэн удирдагч** | Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах үүрэг бүхий этгээд |
| **Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас** | Хөрөнгөөр баталгаажсан, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжинд төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас |
| **Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх** | Зээлдэгч сар тутам зээлийн эргэн төлөлтийн хуваарь дахь төлөх дүнгээс илүү дүнгээр зээлийн үлдэгдлээс хэсэгчлэн, эсхүл бүрэн төлөх тохиолдол |
| **Шаардлага хангахгүй хөрөнгө** | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид болон Үнэт цаас гаргагчийн хоорондын "Хөрөнгө худалдах, худалдаж авах гэрээ", "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-д тодорхойлсон хөрөнгө |
| **Шалгуур үзүүлэлт** | Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан хөрөнгийн багцад тавигдах санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтүүд |

СЗХ
2022.06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ 03

simple asset

# ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржийн холбогдох журмын дагуу Симпл Ассет ТЗК ХХК нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 500,000 ширхэг, 50,000,000,000 төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож байна.

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Симпл Ассет ТЗК ХХК |
| Анхны үүрэг гүйцэтгүүлэгч | Ашид Капитал ББСБ ХХК |
| Үнэт цаасны төрөл | Цалингийн зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас |
| Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ | 100,000 төгрөг |
| Үнэт цаасны тоо ширхэг | 500,000 ширхэг |
| Үнэт цаасны нийт үнийн дүн | 50,000,000,000 төгрөг |
| Үнэт цаасны хугацаа | 18 сар |
| Үнэт цаасны хүү | 15.0 хувь (жилийн) |
| Үнэт цаасны хүүний төлөлт | Улирал тутам |
| Үнэт цаасны үндсэн төлбөрийн төлөлт | Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш<br>12 дахь сард үндсэн төлбөрийн 50%<br>18 дахь сард үндсэн төлбөрийн 50% |
| Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр | Зээлийн багцын үндсэн төлбөр болон хүүний орлого |
| Үнэт цаасны хүүд ногдох татвар | Хүүний орлогын 5.0 хувь |
| Үнэт цаасны хадгалалт | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв |
| Анхдагч зах зээлийн захиалга | Андеррайтер төвтэй |
| Арилжаа эрхлэх байгууллага | Монголын Хөрөнгийн Бирж |
| Арилжааны хэлбэр | Нээлттэй зах зээлд |
| Зээлийн багцын дүн | 50,001,389,249 төгрөг |
| Зээлийн тоо | 12,780 |
| Зээлдэгчдийн тоо | 10,236 |
| Барьцаа | Цалингийн зээлийн багц |
| Зээлийн чанар | 100 хувь хэвийн |
| Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт | Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн санхүүжилт |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
5183855

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ТЗК ХХК

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

## ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

### АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ

**АШИД КАПИТАЛ ББСБ ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 15 давхар

info@simple.mn

(976) 7711-2828

www.simple.mn

### ТЭРГҮҮЛЭГЧ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ

**ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот, 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр, 25 давхар, 2506 тоот

info@ucc.mn

(976) 7777-6377

www.ucc.mn

### ХАМТРАГЧ АНДЕРРАЙТЕРИЙН КОМПАНИ

**МАНДАЛ КАПИТАЛ МАРКЕТС ҮЦК ХХК**

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Мэру Тауэр, 6 давхар, 602 тоот

info@mandal.capital

(976) 7575-9911

www.mandal.capital

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ҮЭК ХХК
9022060074

MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
2022.06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 08 16
БҮРТГЭВ-03

## ЗЭЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ ГАРГАГЧ

### ШОНХОР ҮНЭЛГЭЭ АУДИТ ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, Метро бизнес оффис, 6 давхар, 603 тоот

shonkhor.mn@gmail.com

(976) 7015-0001

www.shonkhor.mn

## ХУУЛИЙН ФИРМ

### ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН

BATBAYAR AND PARTNERS LLP

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Монгол ТВ цамхаг, 10-р давхар

contact@bnp.mn

(976) 7711-9008

www.bnp.mn

## ХӨРӨНГӨ ИТГЭМЖЛЭН УДИРДАГЧ КОМПАНИ

### ЮНАЙТЕД АЙР ФАЙНЭНС ХХК

ЮНАЙТЭД АЙР ФАЙНЭНС

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-хороо, Соёлын төв өргөө 10 давхар 1005 тоот

info@uaf.mn

(976) 7012-2346

www.uaf.mn

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS

СЭХ
2022.06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

simple | asset

# НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН

СЭХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



# 1.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

## Бодит сектор

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөлөөгөөр үйлчилгээ, үйлдвэрлэл, агаарын тээвэр, аялал жуулчлал зэрэг салбаруудын үйл ажиллагаа зогсонги байдалд шилжсэнтэй холбоотойгоор 2020 онд бодит эдийн засаг 4.8 хувиар агшсан бол 2021 оны байдлаар 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2021 оны эхний хагаст Ковид-19 цар тахлаас нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, цар тахлын нөхцөл байдлыг хяналтад байлгах зорилгоор 5 удаагийн 117 хоногийн хөл хориог тогтоосон хэдий ч дэлхийн түүхий эдийн үнийн өсөлтөөс улбаатайгаар эхний улиралд эдийн засаг 14.8 хувиар өссөн. Гэвч 2021 оны сүүлийн хагаст БНХАУ-ын хил, гааль дээр хөл хорио тогтоосонтой холбоотойгоор эдийн засаг аажмаар агшсан. Нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2021 оны байдлаар 43 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 14 хувиар өссөн үзүүлэлт юм.

*Зураг 1. Эдийн засгийн бодит өсөлт, жилийн*




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

2021 оны эхнээс удаан үргэлжилсэн хөл хорио, цар тахлын нөлөөнөөс дотоодын халдварын тоо тасралтгүй нэмэгдсэн нь эдийн засгийн ихэнх салбарт сөргөөр нөлөөлсөн байна. Салбараар нь авч үзвэл барилгын салбар 32.6 хувиар, хөдөө аж ахуйн салбар 5.6 хувиар тус тус агшсан нь бодит өсөлт буурахад голлон нөлөөлсөн бол уул уурхайн салбар 1.7 хувиар өссөн болон бөөний болон жижиглэн худалдаа, мэдээлэл холбооны салбар оны эхнээс сэргэсэн нь эдийн засгийн агшилтыг хязгаарлахад гол хувь нэмэр болсон байна.

СЭХ
2022.06.08 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-15
БҮРТГЭВ-03



*Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл*

| | 2022Т |
|---|---|
| Дэлхийн Банк | 2.5% |
| Олон Улсын Валютын Сан | 2.0% |
| Азийн Хөгжлийн Банк | 2.3% |
| Монголбанк | 2.5% |
| **Дундаж** | **2.3%** |

*Эх сурвалж: Олон Улс болон дотоодын эдийн засгийн институц*

2021 оны 2 дугаар хагасаас дотоод дахь цар тахлын тархалт, вирусийн омикрон хувилбар илэрсэн зэрэгтэй холбоотойгоор БНХАУ-ын зүгээс хилийн боомтуудын үйл ажиллагааг хязгаарлаж эхэлснээр экспортын гарц буураад байна. Хилийн асуудал нь 2022 онд хэвээр үргэлжлэхээр байгаа тул бодит ДНБ-ий өсөлт тус хугацаанд дунджаар 2.3 хувьтай байхаар хүлээгдэж байна.

## Гадаад сектор

2021 онд гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь цэвэр экспортын өсөлтөд эерэг нөлөө үзүүлсэн. 2021 онд бараа, үйлчилгээний экспорт 25.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 20.0 хувиар өсжээ. Харин импорт 25.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.5 хувиар өссөнөөр гадаад худалдааны алдагдал 2021 онд 0.21 их наяд төгрөгт хүрсэн. Үүнд түүхий эдийн бүтээгдэхүүний экспорт 2021 онд өмнөх онтой харьцуулахад 17.0 хувиар өссөн байна. Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнийн өсөлт нь Монгол Улсын экспортын салбарын

*Зураг 2. Экспортын голлох бүтээгдэхүүн, сая ам.доллар*




*Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо*

өсөлтөд эерэгээр нөлөөлсөн бол хэрэглээний бүтээгдэхүүний импорт өмнөх жилээс 31.0 хувиар, хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 12.0 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 63.0 хувиар өсөж, аж үйлдвэрийн орцын импорт 6.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC

## Төсвийн сектор

2021 оны байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн алдагдал 1.3 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн тэнцэл 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Нэгдсэн төсвийн орлого 2020 онд 13.6 хувиар буурч 10.4 их наяд төгрөгт хүрээд байсан бол 2021 онд төсвийн орлого өмнөх оны мөн үеэс 38.0 хувиар өссөн. Тус өсөлтийн 21.0 нэгж хувийг татварын орлого бүрдүүлсэн бол нийгмийн даатгалын орлого 6 нэгж хувийг бүрдүүлж байна.

Татварын орлого 2021 оны байдлаар 11.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 2.8 их наяд төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 48.9 хувиар, нийгмийн даатгалын орлого 42.4 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 28.4 хувиар, гадаад үйл ажиллагааны орлого 27.3 хувиар тус тус нэмэгдсэн нь голлох нөлөөлсөн үзүүлсэн байна.

***Зураг 3. Төсвийн тэнцэл, их наяд төгрөгөөр***




***Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо***

Монгол Улсын Засгийн газраас татвар, нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, урсгал шилжүүлэг, цалин хөлсний зардлыг нэмэгдүүлэх замаар дотоод эдийн засаг дахь эрэлтийг дэмжих зорилгоор мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг 2020 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Цар тахлын нөлөөгөөр 2020 онд Монгол Улсын нийт төсвийн алдагдал ДНБ-ий 9.6 хувьтай тэнцэж байсан бол 2021 оны төсвийн гүйцэтгэлээс харахад 4 орчим хувьтай байна.

Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг багасгах, хүн амын эрүүл мэндийг хамгаалахын тулд Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүд цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна. Иймд цар тахлын нөхцөл байдал сайжрахгүй, эдийн засгийн өсөлт удаашрах бол төсвийн алдагдал 2022 онд ДНБ-ий 3 орчим хувьтай тэнцүү байхаар хүлээгдэж байна.

## Мөнгөний сектор

### Инфляц

Дотоодын хөл хорионы нөхцөл байдал, хил гаалийн хязгаарлалт, тээвэрлэлтийн зардлын өсөлтөөс улбаатайгаар инфляцын түвшин 2021 оны 1 дүгээр улирлын төгсгөлөөс эхлэн

СЗХ
2022.06 сар 16 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



эрчимтэй нэмэгдсэн. Улмаар 2022 оны 3 дугаар сарын байдлаар хэрэглээний үнийн улсын индекс өнгөрсөн оны мөн үеэс 14.4 хувиар өсжээ. Тус өсөлтөд хүнсний бүлгийн үнэ 18.0 хувь, тээврийн бүлгийн үнэ 21.5 хувь, зочид буудлын үйлчилгээний үнэ 18.8 хувь, орон сууцны бүлгийн үнэ 15.0 хувь тус өссөн нь нөлөөлсөн байна.

*Зураг 4. Инфляцын түвшин, жилийн*




*Эх сурвалж: Монголбанк*

Монгол Улсын хэрэглээний сагсны 40.0 орчим хувийг импортын бараа бүтээгдэхүүн эзэлдэг. Импортын барааны үнийн өсөлт нэмэгдэхэд шатахууны үнийн өсөлт голлон нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл, дэлхийн зах зээл дээрх нефтийн үнийн өсөлт, бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хүндрэл, хил гаалийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын хэрэглээний үнэ нийлүүлэлтийн гаралтай өссөн.

*Хүснэгт 2. Инфляцын төсөөлөл*

| | 2022Т |
|---|---|
| Олон Улсын Валютын Сан | 15.5% |
| Азийн Хөгжлийн Банк | 12.4% |
| Монголбанк | 13.0% |
| **Дундаж** | **13.6%** |

*Эх сурвалж: Олон Улс болон дотоодын эдийн засгийн институц*

2022 оны 2 дугаар сард ОХУ болон Украин улсуудын хооронд үүссэн нөхцөл байдал нь нийт импортын 30.0 орчим хувийг ОХУ-аас импортолдог Монгол Улсын хувьд импортын гол бүтээгдэхүүн болох газрын тос, цахилгаан, эрчим хүч, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт тасрах, үнэ нэмэгдэх нөхцөлийг бий болгоод байна.

Үүсээд буй нөхцөл байдал нь хамгийн богино хугацаанд гэхэд 2022 оны 6 дугаар сард намжих төлөвтэй байгаа бөгөөд тээвэр, ложистикийн асуудал 2022 оны 2 дугаар улирал хүртэл үргэлжлэхээр хүлээгдэж байна. Үүнээс хамаарч олон улсын болон дотоодын шинжээчдийн зүгээс Монгол Улсын жилийн инфляцын түвшинг 2022 онд дунджаар 13.6 хувьд хүрнэ гэж төсөөлж байна.

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

СЗХ
2022 он 06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Цаашид цар тахлын нөхцөл байдал сайжрахгүй, хил гааль, тээвэрлэлтийн нөхцөл байдал хэвийн нөхцөлд шилжихгүй бол хэрэглээний үнийн өсөлт төсөөллөөс давж өндөр түвшинд хэвээр хадгалагдах эрсдэлтэй. Тээвэрлэлт, дэлхийн зах зээл дээрх бүтээгдэхүүний үнийн өсөлтөд суурилсан нийлүүлэлтийн гаралтай инфляцад Монголбанкны мөнгөний бодлогын зохицуулалтууд, арга хэрэгслүүд төдийлөн нөлөө үзүүлж чадахгүй төлөвтэй байна.

## Мөнгөний нийлүүлэлт, мөнгөний бодлого

2021 онд мөнгөний нийлүүлэлт өмнөх оноос 15.0 хувиар өсөж, 27.9 их наяд төгрөгт хүрсэн. M2 мөнгөний жилийн өсөлтөд төгрөгийн харилцах 9.1 нэгж хувийн, төгрөгийн хадгаламж 6.8 нэгж хувийн, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 0.4 нэгж хувийн нөлөө үзүүлсэн бол гадаад валютын хадгаламж 2.8 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлжээ.

2021 онд төгрөгийн харилцах өмнөх оноос 64.0 хувиар, төгрөгийн хадгаламж 12.0 хувиар өсжээ. 2020 оны эхнээс эрчимтэй өссөн мөнгөний нийлүүлэлт 2021 оны 2 дугаар улиралд хамгийн өндөр түвшинд хүрсэн бол оны төгсгөлд Ковид-19 цар тахлын өмнөх үетэй ижил түвшинд хүрч буурсан.

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо мөнгөний бодлогын хүүг 2020 онд 6.0 хувьд барьж байсан бол 2022 оны 2 дугаар сарын байдлаар төгрөгийн ханшийг хамгаалах зорилгоор бодлогын хүүг 3.0 нэгж хувиар нэмэгдүүлэн 9.0 хувьд хүргэснээр мөнгөний бодлогын төлөв чангарч, мөнгөний нийлүүлэлт хумигдаж эхэлсэн.

***Зураг 5. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт, хувиар***




***Эх сурвалж: Монголбанк***

2021 оны дунд үеэс иргэд, аж ахуй нэгжийг дэмжих, цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор (1) Монгол Улсын Засгийн Газар эдийн засгийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн (2) Арилжааны банкууд репо санхүүжилт авч иргэд, аж ахуй нэгжид бага хүүтэй зээл тогтмол олгож буй нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд түлхэц болсон.



УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022.06.1
БҮРТГЭВ-03



## Төлбөрийн тэнцэл

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2021 онд 358.6 сая ам.долларын ашигтай, урсгал данс 148 сая ам.долларын алдагдалтай байна. Харин санхүүгийн данс 438.2 сая ам.долларын ашигтай гарлаа.

Ковид-19 цар тахлын тархалт, түүнийг хязгаарлах дэлхийн улсуудын бодлогоос шалтгаалан дэлхий даяар үйлчилгээний салбарын үйл ажиллагааны идэвх саарсан, гадаад үйлчилгээний эрэлт буурсан нь Монгол Улсын төлбөрийн тэнцэл дэх үйлчилгээний алдагдал буурахад голлох нөлөө үзүүлсэн. Тухайлбал, Монгол Улсын төлбөрийн тэнцэл дээрх үйлчилгээний тэнцэл 1,380 сая ам долларт хүрч өмнөх оноос 4.0 хувиар буурсан. Энэ нь дэлхийн ихэнх улсууд Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс үүдэлтэйгээр үйлчилгээний салбарын идэвх саарч, эрэлт буурсантай холбоотой юм.

Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулагч компаниудын үйл ажиллагаа сэргэснээр ногдол ашгийн шилжүүлэг, гадаад ажилтнуудын цалингийн шилжүүлэг нэмэгдэж, анхдагч орлогын алдагдал 2,209 сая ам долларт хүрсэн. Харин хоёрдогч орлого буюу урсгал шилжүүлгийн орох урсгал 20.0 хувиар нэмэгдэж, 328 сая ам.долларт хүрсэн нь цар тахлыг даван туулахад чиглэсэн гадаадын буцалтгүй тусламжийн нөлөөнөөс үүдэлтэй байна.

***Зураг 6. Төлбөрийн тэнцэл, сая доллараар***




***Эх сурвалж: Монголбанк***

## Валютын ханш

2021 онд Монгол Улсын гадаад валютын албан нөөц 4,366 сая ам долларт хүрч өмнөх оноос 3.7 хувиар буурсан нь ДНБ-ий 29.0 хувь, импортын 8 сарын хэрэглээтэй тэнцэж байна. Монголбанк валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд 20 тонн алт худалдаж авсан нь өмнөх оноос 12.2 хувиар буурсан үзүүлэлт юм. Сүүлийн нэг жилийн хугацаанд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн өсөлттэй холбоотой экспортын орлого нэмэгдсэн, эдийн засагт

УЛААНБААТАР ХОТ
ХХК
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC

СЗХ
2022 06 16
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03


хүлээгдэж байсан валютын томоохон гадагшлах урсгал болох Монгол Улсын Засгийн Газрын бондын төлөлтийг дахин санхүүжүүлэх болсон зэргээс шалтгаалж 2021 онд валютын ханш харьцангуй тогтвортой байв.

## 1.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

### Дотоодын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2021 оны байдлаар 5.98 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 2.0 дахин буюу 97.0 хувиар өссөн үзүүлэлт юм. Тодруулбал хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2020 онд ДНБ-ий 8.1 хувьтай тэнцүү байсан бол 2021 оны байдлаар 5.8 нэгж хувиар нэмэгдэж 13.9 хувьд хүрсэн. Энэ нь хөрөнгийн зах зээл хурдацтай тэлж буйг илэрхийлж байна.

*Зураг 7. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр*




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

### Хөрөнгийн зах зээлийн индекс

2021 оны байдлаар Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) дээр арилжаалагддаг хөрвөх чадвар болон зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч 20 хувьцааны хөдөлгөөнийг харуулдаг ТОП-20 индекс 130 хувь, хувьцааны бүртгэлийн I ангиллын хувьцааг илэрхийлдэг MSE A индекс 70 хувь, II ангиллын хувьцааг илэрхийлдэг MSE-B индекс 61 хувийн өсөлтийг тус тус үзүүлсэн.

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS

СЗХ
2022 он 06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-15
БҮРТГЭВ-03



*Зураг 8. Хөрөнгийн биржийн индексүүд*




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

## Хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх

2021 оны байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн арилжааны идэвх 1.4 их наяд төгрөгт хүрсэн нь 2018 оноос 5.8 дахин өссөн үзүүлэлттэй байна. 2020 онд арилжааны дүн Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас улбаалан 65.3 тэрбум төгрөг болж буурсан боловч 2021 онд бодлогын зэрэг өөрчлөлтийн улмаас арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 22 дахин өсөж 1.4 их наяд төгрөгт хүрсэн байна.

*Зураг 9. Хөрөнгийн зах зээлийн арилжааны дүн, тэрбум төгрөгөөр*




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

2021 оны нийт арилжааны 74.0 хувийг компанийн нэлттэй бонд буюу ЭТТ бонд, Монпэй бонд, Лэнд бонд Инвескор бондууд бүрдүүлж байна. Тус хугацаанд Мандал Ирээдүйн Өсөлт Хамтын ХОС, Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн ХК, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК, Богд Банк ХК анхдагч зах зээлд анх удаа болон нэмэлт хувьцаа гаргаж нийтэд санал болгосон.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC

СЗХ
2022 оны 06 сарын 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



# 1.3 ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ОНЦЛОГ

Бодлогын хүүний өөрчлөлт, өндөр инфляцын орчин, эдийн засгийн өсөлтийн удаашралтай зах зээлийн тогтворгүй энэ үед тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний эрэлт хөрөнгө оруулагчдын дунд өндөр байна. Тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүнээс эрсдэлийн түвшинг хамгийн бага түвшинд байлгахаар бүтэцлэгдсэн бүтээгдэхүүн нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь ирээдүйд мөнгөн урсгал бий болгох хөрөнгийг багцалж үнэт цаасжуулсан тул хөрөнгөд тогтмол мөнгөн урсгал бий болгох зээл, лизинг, авлага зэрэг багтдаг.

## Тогтмол өгөөж

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь банкны хадгаламж, Засгийн Газрын болон компанийн бондтой өгөөжийн түвшинд ижил шинж чанартай буюу тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн юм. Өөрөөр хэлбэл, үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь тогтмол хүүний орлого хүлээн авах боломжтой.

## Хөрвөх чадвар

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийн хуваариас шалтгаалан Үнэт цаас эзэмшигч нь үндсэн төлбөрийн тодорхой мөнгөн урсгалыг хугацаанаас өмнө хүлээн авах боломжтой байдаг. Тодруулбал, Симпл хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны хувьд 12 дахь сард Үнэт цаас эзэмшигч нь үндсэн төлбөрийн 50.0 хувийг хүлээн авах боломжтой байгаа нь Үнэт цаас эзэмшигчийн хөрвөх чадварыг хангаж, дахин хөрөнгө оруулалтын боломжийг бий болгож байна.

## Эрсдэлийн саармагжуулалт

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болж байгаа хөрөнгө нь тогтмол мөнгөн урсгал бүхий олон тооны хөрөнгөөс бүрддэг бөгөөд энэхүү багцад тусгай зориулалтын компани (ТЗК)-н Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-с баталсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон цалингийн зээлийн хөрөнгүүд багтсан. Уг шалгуур үзүүлэлтүүдийг хөндлөнгийн санхүүгийн болон хуулийн шинжээч нараар давхар баталгаажуулан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хамгийн найдвартай хөрөнгийг тусгай зориулалтын компани руу шилжүүлснээр зээлийн эрсдэл болон зээлийн төвлөрлийн эрсдэлийг бууруулж байна.

## Хяналтын тогтолцоо

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах үйл ажиллагаанд хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргагч, зээлийн шинжилгээ гаргагч, андеррайтер компаниуд оролцож, эрх бүхий зохицуулагч байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр нийтэд санал болгодог. Түүнчлэн Үнэт цаас гаргагч ТЗК-ийн хөрөнгийг хөндлөнгийн хөрөнгө итгэмжлэн удирдагч компани удирдсанаар үнэт цаасны хяналтын тогтолцоог хангаж ажилладгаараа онцлогтой.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХХК
5183855
9021031195 СТС2120

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ
ХХК



MANDAL CAPITAL MARKETS

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

simple | asset

# ХОЁР. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

## 2.1 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ




***Хүснэгт 3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүртгэлийн мэдээлэл***

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Ашид Капитал ББСБ ХХК |
| Хувьцаа эзэмшигч | М-Си-Эс Холдинг ХХК /100 хувь/ |
| СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дугаар | ТЗ 101/663 |
| Үйл ажиллагааны чиглэл | Зээл, факторингийн үйл ажиллагаа, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2016.09.09 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9015005118 |
| Регистрийн дугаар | 6105572 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 15 давхар |
| Утас | +976 7711-2828 |
| Цахим шуудан | info@simple.mn |
| Цахим хаяг | www.simple.mn |

СИМПЛ АССЕТ ХХК

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК нь дэвшилтэт технологид суурилж, инновацлаг бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хэрэглэгчдийн санхүүгийн харилцаа хялбаршуулах, зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хүн бүрийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон дижитал зээлийн томоохон орон зайг бий болгохоор зорьж буй Банк Бус Санхүүгийн Байгууллага (ББСБ) юм.

Тус компани нь системийн нөлөө бүхий арилжааны банкуудын үйл ажиллагаанд ашиглагддаг банкны core (үндсэн) систем, кредит скоринг, автомат шийдлийн систем, төлбөр, тооцооны систем, харилцагчийг таних үйлдлийн систем, бичиг баримт хадгалалтын автомат систем, Dell, EMC, Oracle, Vmware, Fortinet системийн дэд бүтэц, аюулгүй байдлын системийг ашигладаг, олон улсын банкны системд суурилсан цорын ганц ББСБ юм.

Энэхүү шинэлэг технологи, ухаалаг шийдлийг ашиглан Ашид Капитал ББСБ ХХК нь хэрэглэгчдийн цаг, энерги, мөнгийг хэмнэх зорилгоор Simple зээлийн аппликейшнийг энгийн дизайн, ойлгомжтой шийдэл, хэрэглэхэд хялбар байдлаар бүтээж, 2020 оны 11 дүгээр сард зах зээлд амжилттай нэвтрүүлж, харилцагчдад финтект суурилсан дижитал зээлийн үйлчилгээг үзүүлж байна. Simple нь 2021 оны 6 дугаар сараас хойш дижитал зээлийн багцаар зах зээлд тэргүүлж байна.

## Simple аппликейшн

Simple нь олон улсын стандартыг хангасан кредит скоринг системийн тусламжтайгаар харилцагчдын санхүүгийн чадварт тохирсон зээлийн хэмжээ, хүүг санал болгодог бүрэн автоматжуулсан зээлийн аппликэйшн юм.

Тус аппликэйшн нь анх зах зээлд нэвтрэхэд зөвхөн 10.0 сая төгрөг хүртэлх дижитал зээлийн бүтээгдэхүүнтэй байсан бол 2021 оны 7 дугаар сараас эхлэн Simple 2.0 хувилбарыг танилцуулж дижитал, автомашины, бизнесийн болон худалдан авалтын зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдад санал болгож байна.

***Хүснэгт 4. Ашид Капитал ББСБ ХХК-ийн бүтээгдэхүүний мэдээлэл***

| Бүтээгдэхүүн, үйлчилгээ | Бүтээгдэхүүний онцлог |
|---|---|
| **Дижитал зээл:**<br>Хүү: 1.7-3.0%<br>Хугацаа: 24 сар хүртэл<br>Хэмжээ: 20 сая төгрөг хүртэл | - Ухаалаг утастай бол хэзээ ч, хаанаас ч зээлийн эрхээ урьдчилан мэдэх боломжтой<br>- Кредит скоринг системийн тусламжтай харилцагчийн санхүүгийн чадварт тохирсон зээлийн хэмжээ, хүү, хугацаа санал болгодог<br>- Зээлийн шийдвэр гаргалт хүний оролцоогүй, бүрэн автоматжсан |
| **Бизнесийн зээл:**<br>Хүү: 1.5-2.5%<br>Хугацаа: 36 сар хүртэл<br>Хэмжээ: 1 тэрбум төгрөг хүртэл | - Зээлийн эрхээ урьдчилан мэдэх боломжтой<br>- Онлайнаар буюу simple.mn вэбээр зээлийн хүсэлтээ илгээх<br>- Зээлийн эргэн төлөлтөө Simple аппликейшнээр хийх<br>- Зээлийн шийдвэрийг ажлын 1-3 хоногт гаргана |

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



| | |
|---|---|
| **Автомашины зээл:**<br>Хүү: 1.8-3.0%<br>Хугацаа: 60 сар хүртэл<br>Хэмжээ: 300 сая төгрөг хүртэл | - Зээлийн эрхээ аппликейшнээр дамжуулж урьдчилан мэдэх боломжтой<br>- Зээлийн шийдвэрийг ажлын 2-8 цагт гаргана<br>- Зээлийн эргэн төлөлтөө аппликейшнээр хийнэ |
| **Худалдан авалтын зээл:**<br>Хүү: 0.0-3.0%<br>Хугацаа: 24 сар хүртэл<br>Хэмжээ: 20 сая төгрөг хүртэл | - Одоо аваад 30 хоногийн дотор хүүгүй, шимтгэлгүй эргэн төлөх<br>- Хүүгүй, шимтгэлгүйгээр 4 эсвэл 6 хуваах эргэн төлөх<br>- 24 сар хүртэлх хугацаатай лизингээр хүссэн бараа, бүтээгдэхүүн худалдан авах |
| **Маркетплэйс:** | - Өндөр дүнтэй бараа, бүтээгдэхүүн, чухал худалдан авалт болох аялал, эрүүл мэнд, боловсрол зэрэг үйлчилгээг онлайн орчинд зээлээр шийдэх боломжтой<br>- 69 мерчантын 10,000 гаруй нэр төрлийн бараа, үйлчилгээ төвлөрсөн |
| **Simple Зөвлөх** | - Санхүүгийн байгууллагуудад бүртгэлтэй бүх зээлээ нэг дороос харах<br>- Өр, орлогын харьцаагаа шалгах боломжтой<br>- Санхүүгийн мэдээлэл, контент<br>- Зөвхөн шаардлагатай үедээ л зээл авахыг зөвлөдөг "Санхүүгийн найз" |

***Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн мэдээлэл***

Simple нь зөвхөн зээлийн үйлчилгээ үзүүлэхээс гадна хэрэглэгчдийн санхүүгийн найз байж, тэдэнд өөрийн нөөцийг ухаалаг зарцуулж, шаардлагатай үед л зээл авахыг зөвлөж, харилцагчдын санхүүгийн боловсролыг дэмжиж ажилладаг.




ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS SC

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Simple аппликейшн татсан харилцагчдын тоо 500,000 гаруйд хүрсэн. Тодруулбал, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Simple гэрээт харилцагчдын тоо улиралд дунджаар 66.0 хувиар буюу 2020 онтой харьцуулахад 12.7 дахин өсөж 63,994-д хүрсэн байна.

***Зураг 10. Гэрээт харилцагч, зээлдэгчийн тоо***




***Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн мэдээлэл***

## 2.2 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Хувьцаа эзэмшигчид болон Төлөөлөн удирдах зөвлөл

Монгол Улсын хуулийн этгээд болох М-Си-Эс Холдинг ХХК нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Ашид Капитал ББСБ" ХХК-ийг 100 хувь (55,000,000 ширхэг хувьцаа) дангаар эзэмшдэг.



СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

simple asset

## Толгой компани болох М-Си-Эс Холдинг ХХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид:



**Ж.Оджаргал**
**М-Си-Эс Холдинг ХХК-ийн Захирлуудын зөвлөлийн дарга**

**Боловсрол**

- Нидерландын Вант Улсын Маастрихтийн менежментийн сургууль: Бизнесийн удирдлага – Магистр
- Монгол Улсын удирдлагын хөгжлийн институт: Бизнесийн удирдлагын арга зүйч – Бакалавр
- ЗХУ-ын Киев хотын Политехникийн дээд сургууль: Цахилгааны инженер – Бакалавр

**Туршлага**

- М-Си-Эс Холдинг ХХК: Захирлуудын зөвлөлийн дарга
- Монголиан Майнинг Корпорац: Захирлуудын зөвлөлийн дарга
- М-Си-Эс Интернэйшнл ХХК: Ерөнхий захирал
- Эрчим хүчний удирдах газар: Автоматикийн инженер



**Ж.Од**
**М-Си-Эс Холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч**

**Боловсрол**

- Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Оксфордын их сургууль: Олон улсын харилцаа – Магистр
- ЗХУ-ын Москва хотын Олон улсын харилцааны их Сургууль: Олон улсын харилцаа – Бакалавр

**Туршлага**

- М-Си-Эс Холдинг ХХК: Ерөнхийлөгч
- Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх
- АНУ дахь Монгол Улсын Элчин сайдын яам: Нэгдүгээр нарийн бичгийн дарга
- Гадаад харилцааны яамны Америк, Европын газар: Мэргэжилтэн
- Гадаад харилцааны яамны Гэрээ эрхийн хэлтэс: Мэргэжилтэн
- Монгол Улсаас НҮБ-ын дэргэд суугаа Нью-Йорк дахь байнгын төлөөлөгчийн газар: Атташе
- Гадаад харилцааны яамны Гэрээ эрхийн хэлтэс: Мэргэжилтэн

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16

## Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл:



**Б.Билигүүн**
**ТУЗ-ийн дарга**
**М-Си-Эс Холдинг ХХК-ийн Дэд Ерөнхийлөгч**

**Боловсрол**

- АНУ-ын Техасын их сургууль: Бизнесийн удирдлага – Магистр
- МУИС, Физик электроникийн сургууль: Электроникийн инженер – Бакалавр

**Туршлага**

- М-Си-Эс Холдинг ХХК: Дэд Ерөнхийлөгч
- Анунгоо ХХК: Гүйцэтгэх захирал
- Юнител ХХК: Гүйцэтгэх захирал
- Юнител ХХК: Дэд захирал
- М-Си-Эс Электроникс ХХК: Бизнес менежер
- М-Си-Эс Интернэйшнл ХХК: Инженер



**Л.Гантөмөр**
**ТУЗ-ийн гишүүн**
**М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал**

**Боловсрол**

- Нидерландын Вант Улсын Маастрихтийн менежментийн сургууль: Бизнесийн удирдлага – Магистр
- ШУТИС, Компьютерын техник, менежментийн сургууль: Бизнесийн удирдлага – Бакалавр
- ОХУ-ын Москва хотын удирдлагын академи: Инженер-эдийн засагч – Бакалавр

**Туршлага**

- М-Си-Эс Холдинг ХХК: Гүйцэтгэх захирал
- М-Си-Эс Кока-Кола ХХК: Гүйцэтгэх захирал
- М-Си-Эс Холдинг ХХК: Дэд захирал
- Проктер энд Гэмбл Казахстан компани: Дистрибьюторын үйл ажиллагаа хариуцсан менежер
- Проктер энд Гэмбл Истерн Европ Инк компани: Улс хариуцсан менежер
- Проктер энд Гэмбл Истерн Европ Инк компани: Борлуулалтын менежер
- Проктер энд Гэмбл Казахстан компани: Борлуулалтын менежер
- ЗГХЭГ-ын "Төвлөрлийг сааруулах, нутгийн захиргааг бэхжүүлэх" төслийн удирдлагын нэгж: Төслийн үндэсний зохицуулагч
- ШУТИС, Компьютер техник, менежментийн сургууль: Багш

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



**Г.Мягмаржав**
**ТУЗ-ийн гишүүн**
**М-Си-Эс Инвестмент ХХК-ийн Гүйцэтгэх захирал**

**Боловсрол**

- АНУ-ын ДиВрай их сургууль: Санхүүгийн удирдлага – Магистр
- ШУТИС-КТМС: Санхүүгийн удирдлага – Бакалавр

**Туршлага**

- М-Си-Эс Инвестмент ХХК: Гүйцэтгэх захирал
- Юнител ХХК: Дэд Ерөнхийлөгч, Санхүү эрхэлсэн захирал
- Гоёо ХХК: Дэд захирал
- Энержи Ресурс ХХК: Санхүүгийн менежер
- М-Си-Эс Холдинг ХХК: Санхүүгийн менежер
- Интерпресс ХХК: Санхүүгийн шинжээч

## Бүтэц зохион байгуулалт

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн олон талт харилцаа, түүнд оролцогч талуудын эрх зүйн тэнцвэртэй байдлыг хангасан зохицуулалтыг хэрэгжүүлдэг.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Ашид Капитал ББСБ ХХК нь санхүү, хөрөнгө оруулалтын, эрсдэлийн удирдлагын, борлуулалтын, маркетингийн, мэдээлэл технологийн 5 хэлтэстэй, бизнес хөгжлийн, хүний нөөц захиргааны, бизнесийн зээлийн, хууль, комплаенсийн гэсэн 4 албатайгаар үйл ажиллагаа явуулж байна.

*Схем 1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүтэц зохион байгуулалт*




УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS

СЭХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



Ашид Капитал ББСБ ХХК нь олон ургалч, ялгаатай байдлыг хүндэлж, бүх ажилтнуудтай эн тэнцүү харьцаж, хүн нэг бүрийн хүчин зүтгэл, оролцоог дэмждэг компани юм. Тус компани нь шинэ цагийн хөгжил, технологийн дэвшил, дэлхийн чиг хандлагатай хөл нийлүүлэн, тасралтгүй хөгжиж, бие биенээсээ суралцаж, мэдлэг чадварыг ахиулах боломжийг ажилтнууддаа олгохыг зорин ажилладаг.

## 2.3 ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ

### Санхүүгийн байдлын тайлангийн шинжилгээ

*Хүснэгт 5. Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн байдлын тайлан, сая төгрөгөөр*

| Үзүүлэлтүүд | 2020 | 2021 I | 2021 II | 2021 III | 2021 IV | 2022 I |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 31,095.2 | 17,202.9 | 8,070.0 | 20,515.0 | 12,028.1 | 7,458.9 |
| Зээл (Цэвэр) | 6,393.4 | 19,765.0 | 43,660.4 | 77,266.9 | 114,662.0 | 138,528.9 |
| *Нийт зээл* | *6,499.1* | *19,890.8* | *43,831.8* | *77,814.3* | *116,088.5* | *141,347.3* |
| *Зээлийн эрсдэлийн сан* | *(105.8)* | *(125.8)* | *(171.3)* | *(547.4)* | *(1,426.5)* | *(2,818.4)* |
| Бусад хөрөнгө | 389.2 | 552.5 | 988.9 | 1,394.6 | 2,131.1 | 2,317.6 |
| Үндсэн (биет) ба биет бус хөрөнгө (цэврээр) | 738.5 | 632.6 | 707.1 | 1,107.8 | 933.6 | 758.3 |
| **Нийт хөрөнгө** | **38,616.4** | **38,153.1** | **53,426.6** | **100,284.7** | **129,754.9** | **149,063.8** |
| ББСБ-аас гаргасан өрийн бичиг | - | - | 15,000.0 | 15,000.0 | 25,000 | 40,917.6 |
| Бусад өр төлбөр | 499.1 | 949.1 | 1,368.2 | 3,221.1 | 1,413.7 | 3,304.4 |
| **Нийт өр төлбөр** | **499.1** | **949.1** | **16,368.2** | **18,221.1** | **26,413.7** | **44,222.0** |
| Хувьцаат капитал | 40,000.0 | 40,000.0 | 40,000.0 | 55,000.0 | 55,000 | 55,000.0 |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | (1,882.7) | (2,796.1) | (2,941.6) | (2,936.4) | (1,658.8) | (158.2) |
| Хоёрдогч өглөг | | | - | 30,000.0 | 50,000 | 50,000.0 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **38,117.3** | **37,203.9** | **37,058.4** | **82,063.6** | **103,341.1** | **104,841.8** |
| **Нийт өр төлбөр, өөрийн хөрөнгө** | **38,616.4** | **38,153.1** | **53,426.6** | **100,284.7** | **129,754.9** | **149,063.8** |

***Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан***

### Хөрөнгө (актив)

2021 онд Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт хөрөнгө 129.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 3.4 дахин буюу 236.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. ББСБ салбарын 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр нийт хөрөнгө 2.7 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Үүнээс 4.8 хувийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт хөрөнгө бүрдүүлж байна. Түүнчлэн

СЗХ
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
simple asset
БҮРТГЭВ-03

цэвэр зээлийн хэмжээгээр салбарын 6.0 хувийг эзэлж байгаа нь Ашид Капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаа хурдацтай тэлж буйг илтгэж байна.

Мөн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт хөрөнгө 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 149.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 290.7 хувиар буюу 3.9 дахин өссөн байна.

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт хөрөнгийн 92.9 хувийг цэвэр зээл, 5.0 хувийг мөнгөн хөрөнгө, 2.0 хувийг бусад хөрөнгө бүрдүүлж байна. Тайлант хугацаанд цэвэр зээлийн хэмжээ 138.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.0 дахин өссөн байна.

***Зураг 11. Хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр***




*Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол*

## Зээлийн багц

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Ашид Капитал ББСБ ХХК-ийн зээлийн 85.4 хувийг дижитал зээл бүрдүүлж байна. Тус зээлийн онцлог нь их хэмжээний харилцагчдад бага дүнтэй зээл олгож зээлийн төвлөрлийг бууруулахад чиглэдэг.

Иймд Ашид Капитал ББСБ ХХК-ийн 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар цалингийн зээлийн дундаж үлдэгдэл 3.1 сая төгрөг, топ-40 зээлдэгчийн нийт зээлийн өөрийн хөрөнгөд эзлэх хувь 11.6 хувь байна. Энэ нь тус компанийн зээлийн төвлөрөл бага болохыг илтгэж байна.

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS

СЗХ
2022 .06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 16
БҮРТГЭВ-03
simple asset

*Зураг 13. Зээлийн бүтэц, хувиар*




*Зураг 12. Зээлийн үлдэгдэл, чанараар*




*Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол*

2020 онд Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт зээлийн хэмжээ 6.5 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байсан бол 2021 онд 17.9 дахин өсөж, 116.1 тэрбум төгрөгт хүрсэн. Нийт зээлд эзлэх чанаргүй зээл 1.6 хувь, хугацаа хэтэрсэн зээл 1.2 хувь байна. Энэ нь 2021 оны ББСБ салбарын чанаргүй зээлийн дундаж түвшин болох 7.0 хувьтай харьцуулахад 5.8 нэгж хувиар бага буюу Ашид Капитал ББСБ ХХК-ийн зээлийн багцын чанар сайн байгааг илэрхийлж байна. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт зээл 141.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 7.1 дахин өссөн байна. 21.7 дахин өссөн

## Эх үүсвэр (пассив)

2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт хөрөнгийн 29.7 хувийг өр төлбөрөөр, 70.3 хувийг эздийн өмчөөр санхүүжүүлсэн байна. Энэ нь компани нь санхүүгийн хөшүүрэг багатай болохыг илтгэж байна. Ашид Капитал ББСБ ХХК-ийн хоёрдогч өглөг өмнөх оны мөн үеэс 50.0 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, өөрийн хөрөнгийн хэмжээ 104.8 тэрбум төгрөгт хүрсэн.

Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт өр төлбөр 2022 оны 1 дүгээр улиралд 44.2 тэрбум төгрөгт хүрсэн. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн 52.3 хувийг хувьцаат капитал, 47.7 хувийг хоёрдогч өглөг эзэлж байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК



УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS LLC

Зураг 14. Өр төлбөрийн бүтэц, хувиар




Зураг 15. Өөрийн хөрөнгийн бүтэц, тэрбум төгрөгөөр




*Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол*

## Орлогын тайлангийн шинжилгээ

*Хүснэгт 6. Ашид Капитал ББСБ ХХК-ийн орлогын тайлан, сая төгрөгөөр*

| Үзүүлэлтүүд | 2020 | 2021 I | 2021 II | 2021 III | 2021 IV | 2022 I |
|---|---|---|---|---|---|---|
| **Хүүний орлого** | **482.8** | **891.4** | **2,676.2** | **6,553.8** | **12,753.6** | **7,556.8** |
| Зээлийн хүүний орлого | 337.9 | 614.3 | 2,333.0 | 6,038.3 | 12,123.8 | 7,518.1 |
| Бусад хүүний орлого | 144.9 | 277.1 | 343.2 | 515.5 | 629.9 | 38.8 |
| **Хүүний зардал** | **-** | **-** | **(256.4)** | **(1,645.5)** | **(3,576.4)** | **(2,593.6)** |
| Хоёрдогч өглөгийн хүүний зардал | - | - | - | (897.5) | (2,307.9) | (1,602.7) |
| Өрийн бичгийн хүүний зардал | - | - | (256.4) | (747.9) | (1,268.47) | (987.1) |
| Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | - | - | - | - | - | (3.7) |
| **Цэвэр хүүний орлого** | **482.8** | **891.4** | **2,419.8** | **4,908.3** | **9,177.2** | **4,963.3** |
| **Хүүний бус орлого** | **310.0** | **24.1** | **266.8** | **315.9** | **377.3** | **77.8** |
| Ханш болон үнэлгээний тэгшигтгэлийн орлого | 309.7 | 2.9 | 203.6 | 204.5 | 204.5 | 0.6 |
| Санхүүгийн үйлчилгээний орлого | 0.3 | 21.1 | 63.2 | 111.4 | 172.8 | 77.2 |
| **Хүүний бус зардал** | **(2,702.6)** | **(1,775.3)** | **(3,636.6)** | **(5,726.9)** | **(7,702.7)** | **(1,929.8)** |
| Арилжаа болон ханшийн тэгшитгэлийн зардал | (43.8) | (114.8) | (200.1) | (221.8) | (221.8) | - |
| Боловсон хүчний холбогдолтой зардал | (1,836.5) | (712.8) | (1,523.1) | (2,695.8) | (3,626.7) | (980.6) |
| Бусад зардал | (822.6) | (947.7) | (1,913.3) | (2,809.4) | (3,854.6) | (949.3) |

СЭХ
2022 .06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 16
БҮРТГЭВ-03



| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Цэвэр хүүний бус орлого/зардал** | **(2,392.6)** | **(1,751.2)** | **(3,369.8)** | **(5,411.0)** | **(7,325.4)** | **(1,852.0)** |
| **Эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал** | **(1,909.8)** | **(859.8)** | **(950)** | **(502.7)** | **1,851.8** | **3,111.2** |
| Болзошгүй эрсдэлийн зардал | (105.8) | (20.7) | (66.2) | (469.7) | (1,370.6) | (1,391.9) |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал** | **(2,016.0)** | **(880)** | **(1,016.0)** | **(972)** | **481.23** | **1,719.3** |
| Үндсэн бус үйл ажиллагааны орлого | 1.5 | 0.8 | 0.9 | 1.5 | 1.5 | 0.1 |
| Үндсэн бус үйл ажиллагааны зардал | (59.2) | (6.0) | (9.3) | (31.2) | (122.4) | (20.8) |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал** | **(2,073.3)** | **(885.7)** | **(1,024.6)** | **(1,002.2)** | **360.4** | **1,698.6** |
| Орлогын албан татварын зардал | 190.6 | (27.7) | (34.3) | (51.6) | (136.5) | (198.0) |
| **Цэвэр ашиг /алдагдал** | **(1,882.7)** | **(913.4)** | **(1,058.9)** | **(1,053.7)** | **223.8** | **1,500.6** |

*Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан*

2021 оны байдлаар Ашид Капитал ББСБ ХХК-ийн нийт хүүний орлого 12.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 26.4 дахин, цэвэр хүүний орлого 9.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулахад 19.0 дахин өссөн. Энэ нь ББСБ салбарын орлогын 2.4 хувийг бүрдүүлж байна. Улмаар 2021 онд компанийн татварын дараах цэвэр ашиг 223.8 сая төгрөгт хүрсэн. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар цэвэр хүүгийн орлого 5.0 тэрбум төгрөгт хүрч, цэвэр ашиг нь 1.5 тэрбум төгрөгөөр хэмжигдэж байна. Цэвэр ашгийн маржин 2021 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.8 хувь байсан бол 2022 оны 1 дүгээр улиралд 19.9 хувь болж өссөн байна.

*Зураг 16. Хүүгийн орлого, тэрбум төгрөгөөр*




*Зураг 17. Цэвэр ашиг, тэрбум төгрөгөөр*




*Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан, Шинжээчийн тооцоолол*

СЭХ
2022 .06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

simple asset

## Санхүүгийн харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

*Хүснэгт 7. Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүд*

| | 2020 | 2021 | 2022 I |
|---|---|---|---|
| **Ашигт ажиллагаа** | | | |
| Цэвэр хүүний орлогын маржин ХО/НХ | 100% | 72.0% | **65.7%** |
| Цэвэр ашгийн маржин ЦА/ХО | (390.0%) | 1.8% | **19.9%** |
| Нийт хөрөнгийн өгөөж ЦА/НХ | (4.90%) | 0.17% | **4.0%** |
| Өөрийн хөрөнгийн өгөөж ЦА/ЭӨ | (4.90%) | 0.21% | **10.9%** |
| Цэвэр зээл/Нийт хөрөнгө | 16.60% | 88.38% | **92.9%** |
| **Санхүүгийн хөшүүрэг** | | | |
| Өр төлбөр/ Эздийн өмчийн харьцаа | 1.30% | 25.5% | **42.2%** |
| Өр төлбөр/ Нийт хөрөнгийн харьцаа | 1.30% | 20.3% | **29.7%** |
| **Хөрвөх чадвар** | | | |
| Эргэлтийн харьцаа | 75.9 | 91.1 | **44.2** |

*Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол*

### Ашигт ажиллагаа

Хөрөнгийн өгөөж болон Эздийн өмчийн өгөөжийн харьцаа нь компани хөрөнгө болон эздийн өмч ашиглан хэдий хэмжээний ашиг бий болгож буйг илэрхийлэх ашигт ажиллагааны үзүүлэлт юм. Ашид Капитал ББСБ ХХК нь 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 1.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласнаар нийт хөрөнгийн өгөөж 4.0 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 10.9 хувь болж өссөн байна.

Цэвэр хүүний маржин нь санхүүгийн байгууллагад тооцдог өндөр ач холбогдолтой үзүүлэлт бөгөөд тухайн компанийн зээл, факторинг, хөрөнгө оруулалт гэх мэт хүүний түвшний өөрчлөлттэй өндөр хамааралтай эргэлтийн хөрөнгөөрөө хэдий хэмжээний цэвэр хүүний орлого бүрдүүлж байгааг илэрхийлдэг. Тус үзүүлэлт нь Ашид Капитал ББСБ ХХК-ийн хувьд 65.7 хувь байгаа нь компанийн санхүүжилт болон зээлийн үйл ажиллагааны үр ашигтай байдлыг харуулж байна.

### Хөрвөх чадвар

Эргэлтийн харьцаа нь компани богино хугацаат өр төлбөрөө эргэлтийн хөрөнгөөр барагдуулах боломжтой эсэхийг харуулдаг хөрвөх чадварын үзүүлэлт юм. Ашид Капитал ББСБ ХХК-ий эргэлтийн харьцаа 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 44.2 байгаа нь компани нь богино хугацаат өр төлбөрийг эргэлтийн хөрөнгөөр барагдуулах өндөр чадамжтай байгааг илэрхийлж байна.

Эрсдэлийн сан байгуулалтын харьцаагаар тухайн компани байгуулсан эрсдэлийн сангаараа чанаргүй зээлийн хэдэн хувийг хаах чадвартай байгааг харуулдаг. Ашид Капитал ББСБ ХХК нь 2021 оны эцсээр чанаргүй зээлийн 102 хувийн түвшинд эрсдэлийн сан байгуулсан нь зээлийн чанаргүйдлийн улмаас хөрвөх чадвар алдагдах эрсдэлийг бууруулж байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ
ХХК



MANDAL CAPITAL
MARKETS
LLC

СЗХ
2022.06.08 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



**Санхүүгийн хөшүүрэг**

Өр төлбөр, эздийн өмчийн харьцаагаар тухайн компани эздийн өмчийн дүнгээс хэд дахин өндөр дүнгээр өр төлбөрийн санхүүжилт татсан байгааг илэрхийлдэг. 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Ашид Капитал ББСБ ХХК-ийн эздийн өмч нийт өр төлбөрөөс 2.4 дахин өндөр байна. Энэ нь компанийн санхүүгийн хөшүүрэг бага болохыг илтгэж байна.

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн шинжилгээ

СЗХ-оос баталсан "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ын дагуу ББСБ нь 18 шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах шаардлагатай байдаг.

Тус зохистой харьцааны үзүүлэлтийг Ашид Капитал ББСБ ХХК нь үйл ажиллагаа эхэлснээс хойш тогтмол хангаж ажиллаж байна. Тодруулбал, 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар Ашид Капитал ББСБ ХХК нь хангалттай өөрийн хөрөнгөтэй, төлбөр гүйцэтгэх чадвар маш сайн, зээлийн багцын төвлөрөл бага, гадаад валютын эрсдэл бага, гадны эх үүсвэр ашиглаагүй буюу зохистой харьцааны үзүүлэлтүүдийг бүрэн хангасан байна.

*Хүснэгт 8. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт хангасан байдал*

| Д/д | Зохистой үзүүлэлтүүд | Байвал зохих | Тайлангаар | Хангасан эсэх |
|---|---|---|---|---|
| | **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт** | | | |
| 1 | Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 38.3% | Хангасан |
| 2 | Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа | 20%-аас доошгүй | 73.2% | Хангасан |
| 3 | Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа | 10%-аас доошгүй | 36.8% | Хангасан |
| | **Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа** | | | |
| 4 | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 8%-аас дээш | 16.9% | Хангасан |
| | **Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт** | | | |
| 5 | Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+илүү,- дутуу ) | 1,839,977.6-с доошгүй | 2,818,420.3 | Хангасан |
| 6 | Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 30%-аас хэтрэхгүй | 0.7% | Хангасан |
| 7 | ББСБ-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 70%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 8 | ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, | 25%-аас хэтрэхгүй | 0.4% | Хангасан |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16



| | | | | |
|---|---|---|---|---|
| | төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа | | | |
| 9 | ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.3% | Хангасан |
| 10 | Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 11 | Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 12 | Монголын хөрөнгийн биржийн "I", "II" ангиллын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 13 | Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 20%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 14 | Бусад үнэт цаас, үнэт цаасны эзэмшлийн зохистой харьцаа | 10%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| | **Гадаад валютын ханшийн эрсдэл** | | | |
| 15 | Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | (+/-40%) | 0.0% | Хангасан |
| | **Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд** | | | |
| 16 | Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа | 80%-аас хэтрэхгүй | 0.0% | Хангасан |
| 17 | Өрийн бичгийн зохистой харьцаа | 50%-аас хэтрэхгүй | 39.0% | Хангасан |
| | **Үндсэн хөрөнгийн үзүүлэлт** | | | |
| 18 | Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа | 15%-аас хэтрэхгүй | 0.1% | Хангасан |

*Эх сурвалж: Ашид Капитал ББСБ ХХК-ийн СЗХ-ны тайлан*

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ
ХХК



MANDAL CAPITAL
MARKETS ISC

simple | asset

# ГУРАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

СЗХ 2022 он 06 сар 08 өдөр БҮРТГЭВ №31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022.06.16
БҮРТГЭВ-03



## 3.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11.1-т заасны дагуу Үнэт цаас гаргагч Симпл Ассет ХХК нь 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. 2022 оны .... сарын .... өдрийн СЗХ-ны ..... тоот тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авснаар Симпл Ассет ТЗК ХХК болж өөрчлөгдсөн.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т "Баталгаат үнэт цаас гаргах тусгай зориулалтын компанийг банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон СЗХ-оос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага байгуулах эрхтэй" гэж заасан. Иймд тус хууль журмын дагуу Үнэт цаас гаргагчийг Ашид Капитал ББСБ ХХК үүсгэн байгуулж, 100 хувь эзэмшдэг болно.

***Хүснэгт 9. Үнэт цаас гаргагчийн бүртгэлийн мэдээлэл***

| | |
|---|---|
| Байгууллагын нэр | Симпл Ассет ТЗК ХХК |
| Хувьцаа эзэмшил | Ашид Капитал ББСБ ХХК /100 хувь/ |
| Үйл ажиллагааны чиглэл | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2022.04.13 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011838466 |
| Регистрийн дугаар | 6852688 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сэнтрал тауэр, 15 давхар |
| Утас | +976 7711-2828 |
| Цахим шуудан | info@simple.mn |
| Цахим хаяг | www.simple.mn |
| Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | 1,000,000 төгрөг |
| Нэрлэсэн үнэ | 1,000,000 төгрөг |
| Тоо ширхэг | 1 ширхэг |

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЭХ
2022 он 06 сар 08
БҮРТГЭВ
№ 01

simple asset

## 3.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал /цаашид ХЭХ гэх/-ын бүрэн эрхийг Ашид Капитал ББСБ ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ.

### Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)

Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллах Төлөөлөн удирдах зөвлөлтэй байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагаандаа ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг баримтлана. ТУЗ нь 3-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлсөн эсхүл аливаа шалтгаанаар гишүүний эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурал нөхөн сонгоно.

ТУЗ нь улирал нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай гэж үзвэл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар ээлжит бус хурлыг хуралдуулж болно.

ТУЗ нь дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дүрмийн хэрэгжилтийг хангуулах
- ТЗК-ийн хөрөнгийг хадгалж, хамгаалах
- Гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр компанийн өдөр тутмын удирдлагыг гүйцэтгүүлэх
- Компанийн хөрөнгийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасан хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эзэмшил, удирдлагад шилжүүлэх. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулснаас хойш хууль тогтоомжид заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглоно.
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан эрх үүргийн дагуу хяналт тавих
- Компанийн зөвшөөрөгдсөн ажил хэрэг болон үйл ажиллагаатай холбоотой гэрээ болон бусад баримт бичиг байгуулах
- Компанийн нэр дээр банкны данс нээлгэх
- Компанийн худалдан авсан зээлийн хөрөнгөд үйлчилгээ үзүүлж буй этгээдийн гүйцэтгэлийнг хянах, шаардлагатай бол тэдгээрийг солих санал гаргах
- Компани нь өөрийн байгуулсан гэрээ болон бусад баримт бичгүүдээр Компанид олгогдсон бүх эрх болон эрх хамгаалах хэрэгслийг хэрэгжүүлэх
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулж буй хууль тогтоомж, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн биржийн журам болон

Компанийн дүрэм, Компанийн дотооддоо дагаж мөрдөж буй журам, заавартзаасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлэх

## Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд



**Д.Баярсайхан**
**ТУЗ-ийн дарга, Хараат бус гишүүн**

**Боловсрол**

- Токиогийн Их Сургууль: Санхүү, хөрөнгө оруулалт-Магистр
- Хитоцубаши Их Сургууль: Эдийн засаг - Бакалавр

**Туршлага**

- Лонг Терм Партнерс оф Монголиа ХХК: Гүйцэтгэх захирал
- Дэлхийн Банк, Олон улсын санхүүгийн корпорац: Хөрөнгө оруулалтын мэргэжилтэн
- М Си Эс Холдинг: Хөрөнгө оруулалтын менежер
- Deutsche Bank: Хувьцааны трэйдэр



**Э.Сэлэнгэ**
**ТУЗ-ийн хараат бус гишүүн**

**Боловсрол**

- Викториагийн Их Сургууль: Бизнесийн удирдлага
- Кюүшүгийн Их Сургууль: Япон хэл, соёл судлал
- Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль: Япон хэл судлал - Бакалавр

**Туршлага**

- Анд Глобал: Хүний нөөц, Байгууллагын соёл хариуцсан захирал
- MUFG Bank Ulaanbaatar Representative Office: Assistant Vice President
- Knit Field Limited, Shima Seiki Mongolia: Гадаад харилцааны менежер
- Marubeni Corporation Ulaanbaatar Liaison Office: Менежер



**Б.Тэмүүлэн**
**ТУЗ-ийн гишүүн**

Боловсрол

- Күйн Мэригийн их сургууль: Банк, санхүү – Магистр
- Швед Улсын Ионшопин олон улсын бизнесийн дээд сургууль: Бизнесийн удирдлага – Бакалавр

Туршлага

- Ашид Капитал ББСБ ХХК: Гүйцэтгэх захирал
- М ХХК: Судалгаа хөгжүүлэлт, бизнес хөгжлийн албаны дарга
- М-Си-Эс Холдинг ХХК: Хөрөнгө оруулалтын ахлах менежер
- М-Си-Эс Металс ХХК: Бизнес хөгжлийн менежер
- Энержи Ресурс ХХК: Санхүүгийн шинжээч

### Гүйцэтгэх удирдлага

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу ТЗК нь хөдөлмөрийн гэрээний дагуу ажилтан авч ажиллуулж болохгүй тул Гүйцэтгэх удирдлага томилохгүй.

## 3.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЭХЛЭЛТИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зориулалттай ТЗК-ийн хувьд эхлэлтийн санхүүгийн тайлан нь доорх байдалтай байна. Үүнд нийт хөрөнгө нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК-аас шилжүүлсэн 50.0 тэрбум төгрөгийн зээлийн хөрөнгө болон 1.0 сая төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээр хэмжигдэж байна.

***Хүснэгт 10. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс, сая төгрөгөөр***

| **Үзүүлэлт** | |
|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 1 |
| Нийт зээл | 50,000 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **50,001** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 50,000 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **50,000** |
| Хувьцаат капитал | 1 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **1** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **50,001** |

***Эх сурвалж: : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл***

# 3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ТӨСӨӨЛӨЛ

## Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайланг үнэт цаасны нөхцөл болон бусад мөнгөн урсгалын үзүүлэлтийг нэгтгэн дараах байдлаар төсөвлөсөн болно.

*Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр*

| Үзүүлэлт | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал |
|---|---|---|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө | 1 | 172 | 3,862 | 12,655 | 3,509 | 16,340 | 63 |
| Нийт зээл | 50,000 | 56,695 | 52,084 | 42,432 | 25,747 | 23,621 | 14,639 |
| Хэвийн | | 52,755 | 48,258 | 38,843 | 22,505 | 20,806 | 12,271 |
| Анхаарал хандуулах | | 3,539 | 2,855 | 2,247 | 1,627 | 1,014 | 464 |
| Чанаргүй | | 401 | 971 | 1,342 | 1,615 | 1,801 | 1,904 |
| Эрсдэлийн сан | - | (191) | (363) | (601) | (751) | (1,183) | (1,454) |
| Хуримтлагдсан хүүний авлага | - | 500 | 518 | 469 | 296 | 273 | 160 |
| **Нийт хөрөнгө** | **50,001** | **57,176** | **56,102** | **54,955** | **28,800** | **39,052** | **13,408** |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны өглөг | 50,000 | 50,000 | 50,000 | 50,000 | 25,000 | 25,000 | - |
| Бусад өглөг | - | 7,021 | 5,473 | 3,981 | 2,729 | 12,924 | 12,231 |
| **Өр төлбөрийн дүн** | **50,001** | **57,021** | **55,473** | **53,981** | **27,729** | **37,924** | **12,231** |
| Хувьцаат капитал | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Хуримтлагдсан ашиг | - | - | - | 700 | 700 | 700 | 700 |
| Татварын дараах ашиг | - | 154 | 628 | 273 | 371 | 428 | 476 |
| **Нийт өөрийн хөрөнгө** | **1** | **155** | **629** | **974** | **1,072** | **1,128** | **1,177** |
| **Өр төлбөр ба эзний өмч** | **50,001** | **57,176** | **56,102** | **54,955** | **28,800** | **39,052** | **13,408** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын болон орлогын тайлангийн төсөөллийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлж буй зээлийн багцаас орох мөнгөн урсгал болон төлөвлөгдсөн зардалд үндэслэж боловсруулсан. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны үндсэн төлбөрийг үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 12 дахь сар болон хугацааны эцэст төлж барагдуулах тул тус хугацаанд зээлийн хөрөнгө буурч буй үзүүлэлттэй байна.

Үнэт цаасны төлбөрийг бүрэн төлж дууссанаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу ТЗК нь татан буугдаж, үүсгэн байгуулагч Ашид Капитал ББСБ ХХК-д холбогдох хөрөнгийг шилжүүлнэ.

## Орлогын тайлангийн төсөөлөл

*Хүснэгт 12. Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл*

| Үзүүлэлтүүд | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал |
|---|---|---|---|---|---|---|
| Хүүний орлого | 2,968 | 3,133 | 2,998 | 2,558 | 1,791 | 1,546 |
| ХБҮЦ-ийн хүүний төлбөр | (1,890) | (1,870) | (1,849) | (1,890) | (945) | (935) |
| **Цэвэр хүүний орлого** | **1,068** | **1,264** | **1,149** | **668** | **846** | **612** |
| Эрсдэлийн сангийн зардал | (191) | (172) | (239) | (150) | (431) | (272) |
| **Эрсдэлийн сангийн дараах ашиг** | **877** | **1,091** | **911** | **518** | **414** | **340** |
| Үйл ажиллагааны зардал | (705) | (565) | (528) | (409) | (352) | (286) |
| **Татварын өмнөх ашиг** | **172** | **527** | **383** | **109** | **63** | **54** |
| Татвар | (17) | (53) | (38) | (11) | (6) | (5) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **154** | **474** | **345** | **98** | **57** | **48** |

*Эх сурвалж: : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

## Зардлын төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үнэт цаас гаргагч нь хүүний болон үндсэн төлбөрийг Үнэт цаас эзэмшигчид олгохоос өмнө хөрөнгө итгэмжлэн удирдагчийн ажлын хөлс, үйлчилгээ үзүүлэгчийн ажлын хөлс, хөндлөнгийн аудитын ажлын хөлс, ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардлыг төлнө.

*Хүснэгт 13. Үнэт цаас гаргахтай холбоотой зардал*

| № | Зардлын зориулалт | Дүн | Давтамж |
|---|---|---|---|
| 1 | Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр | Удирдаж буй хөрөнгийн 0.6 хувь | Сар бүр |
| 2 | Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр | Цуглуулсан төлбөрийн 1.5 хувь | Сар бүр |
| 3 | Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр | 1.0 сая төгрөг | Жил бүр |
| 4 | Ерөнхий ба удирдлагын зардал | 37.0 сая төгрөг | Сар бүр |

*Эх сурвалж: : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

### Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр

Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК-ийн хооронд байгуулсан Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн бүхий л мөнгөн хөрөнгийг удирдах үүрэгтэй. Иймд тус үйлчилгээний

төлбөр болгож удирдаж буй хөрөнгийн 0.6 хувийг сар бүр Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани болох Юнайтед Айр Файнэнс ХХК-д төлнө.

**Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр**

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үйлчилгээ үзүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн багцын зээлийн эргэн төлөлтийг дараа сарын 10-ны өдөрт багтаан холбогдох авлагыг суутган төлбөр цуглуулах данс руу шилжүүлэх үүрэгтэй. Энэхүү үйлчилгээтэй төлбөр нь цуглуулсан төлбөрийн 1.5 хувьтай тэнцэнэ.

Үйлчилгээ үзүүлэгч нь "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын 2.3.4-т заасны дагуу зээлийн эргэн төлөлтийг тооцоолсон зээлийн данс бүртгэлийг хөтөлж, зээлийн болон төлбөрийн мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч компанид хүргүүлэн тайлагнана.

**Ерөнхий ба удирдлагын зардал**

Үнэт цаас гаргагчийн компанийн ерөнхий үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардал нь сар бүр 37.0 сая төгрөг байна.

**Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр**

СЗХ-ны "ХБҮЦ гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 8.1-т заасны дагуу Үнэт цаас гаргагч нь жилд нэгээс багагүй удаа аудит хийлгэх шаардлагатай. Тус хүрээнд Үнэт цаас гаргагч нь Шонхор Үнэлгээ Аудит ХХК-тай Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Тус гэрээний төлбөрт жилийн 1.0 сая төгрөгийг төлөх болно.

## Мөнгөн урсгалын төсөөлөл

*Хүснэгт 14. Үнэт цаас гаргагчийн мөнгөн урсгалын төсөөлөл*

| Үзүүлэлт | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал |
|---|---|---|---|---|---|---|
| Хүүний орох мөнгөн урсгал | 1,479 | 1,567 | 1,442 | 1,080 | 782 | 579 |
| Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал | 25,954 | 26,579 | 24,152 | 16,685 | 13,126 | 8,982 |
| ХБҮЦ-ийн үндсэн төлбөр | - | - | - | (25,000) | - | (25,000) |
| ХБҮЦ-ийн хүүний төлбөр | (1,890) | (1,870) | (1,849) | (1,890) | (945) | (935) |
| Үйл ажиллагааны зардал | (706) | (565) | (528) | (409) | (342) | (277) |
| Татварын зардал төлсөн төлбөр | (17) | (53) | (38) | (11) | (6) | (5) |
| **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **24,820** | **25,658** | **23,179** | **(9,546)** | **12,615** | **(16,656)** |
| Хадгаламжийн хүүний орлого | - | - | 114 | 399 | 227 | 388 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт | (24,649) | (21,968) | (14,500) | - | - | - |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал** | **(24,649)** | **(21,968)** | **(14,386)** | **399** | **227** | **388** |
| Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл | 1 | 172 | 3,862 | 12,655 | 3,509 | 16,340 |
| Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 172 | 3,862 | 12,655 | 3,509 | 16,351 | 72 |
| **(Харилцах, Хадгаламж+ Зээл)/ХБҮЦ** | **114%** | **112%** | **110%** | **117%** | **160%** | **162%** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

## 3.5 ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

**Төлбөр цуглуулах данс**

ТЗК нь Үйлчилгээ үзүүлэгчийн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. Тус дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь хөрөнгө итгэмжлэн удирдагч компани байна.

**Зээлийн эргэн төлөлтийн данс**

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Тус дансны захиран зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч байна.

simple | asset

# ДӨРӨВ. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 4.1 ҮНЭТ ЦААСЖУУЛАХ ХЭЛЦЭЛ

Симпл ХБҮЦ-ыг зах зээлд санал болгох, үнэт цаасжуулах хэлцэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч/Үүсгэн байгуулагчаар Ашид Капитал ББСБ ХХК, Андеррайтераар Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК болон Мандал Капитал Маркетс ҮЦК ХХК, Хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргагчаар Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН, Зээлийн шинжилгээ гаргагчаар Шонхор Үнэлгээ Аудит ХХК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар Юнайтед Айр Файнэнс ХХК нар ажилласан. Үнэт цаасжуулах хэлцэл нь дараах байдалтай байна.

*Схем 2. Үнэт цаасжуулах хэлцэл*




### ТЗК байгуулах

ТЗК нь баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Ашид Капитал ББСБ ХХК нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу Симпл Ассет ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан.

### Үнэт цаасжуулах зээлийн /хөрөнгийн/ багцыг сонгон шалгаруулах

Хөрөнгийн багцад ТУЗ-с баталсан хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгогдсон цалингийн зээлийн хөрөнгүүд багтсан. Уг шалгуур үзүүлэлтүүдийг хөндлөнгийн санхүүгийн болон хуулийн шинжээч нараар давхар баталгаажуулан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангасан хөрөнгийг ТЗК руу шилжүүлнэ.

**Багцад багтсан хөрөнгүүд шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн дүгнэлт гаргуулах**

Хөрөнгийн багцын шалгуурын дагуу ХБҮЦ-ны зээлийн хөрөнгө хуулийн болон санхүүгийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН, зээлийн шинжилгээг Шонхор Үнэлгээ Аудит ХХК боловсруулсан.

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК руу хөрөнгө шилжүүлэх**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг ТЗК-тай гэрээ байгуулсны үндсэн дээр шилжүүлнэ. Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн гэрээ үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно.

**Үнэт цаасыг СЗХ, МХБ-д бүртгүүлэх**

Андеррайтерууд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ.

**Анхдагч зах зээлийн захиалгыг зохион байгуулах**

Зохицуулагч байгууллагуудаас зөвшөөрөл олгогдсоны дараа Андеррайтерууд нь үнэт цаасыг нийтэд танилцуулах, сурталчлах ажиллагааг зохион байгуулж, андеррайтер төвтэй анхдагч зах зээлийн захиалгыг хүлээн авч гүйцэтгэнэ.

**Хөрөнгө оруулагчид үнэт цаас худалдаж авах**

Үнэт цаасны захиалга нээгдэх хугацаанд үнэт цаас эзэмших хүсэлтэй хөрөнгө оруулагчид Үнэт цаасны төвлөрсөн хадгаламж дах үнэт цаасны дансанд мөнгийг байршуулж, захиалгыг хийж гүйцэтгэнэ. Захиалга биелснээр үнэт цаас хөрөнгө оруулагчийн эзэмшилд шилжиж, үнэт цаасны танилцуулгад заасан төлбөрийн хуваарийн дагуу хүүний болон үндсэн төлбөрийг хүлээж авна.

**Хөрөнгийг удирдах**

Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юнайтед Айр Файнэнс ХХК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгөтэй холбоотой бүртгэх, тайлагнах болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээг үнэт цаасны хугацааны турш үзүүлнэ.

**ТЗК татан буугдах**

Баталгаат үнэт цаастай холбогдсон үүрэг дуусгавар болмогц ТЗК нь татан буугдана.

## 4.2 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүний шинж чанарын хувьд хадгаламж, Засгийн газрын үнэт цаас, компанийн нээлттэй болон хаалттай бондтой харьцуулагдах боломжтой.

Монгол Улсын Засгийн Газрын үнэт цаас нь дотоодын зах зээлд арилжаалагддаггүй, хаалттай бонд нь мэргэжлийн буюу хязгаарлагдмал хөрөнгө оруулагчдад зориулсан тул Симпл ХБҮЦ-ны хүүний түвшинг банкны хадгаламж болон компанийн нээлттэй бонд, ХБҮЦ-тай харьцуулах замаар тогтоосон.

Симпл ХБҮЦ-ны хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх үүднээс хүүний түвшинг 1) макро эдийн засгийн орчинтой уялдуулж, инфляцын түвшнээс өндөр буюу мөнгөний үнэ цэнийг алдагдуулахгүй байхаар 2) банкны хадгаламжаас өндөр байхаар тогтоосон. Тус үндэслэлээр Симпл ХБҮЦ-ны хүүний түвшинг 15.0 хувиар тодорхойлсон.

### Инфляцын түвшинтэй харьцуулахад

2022 оны 3 дугаар сарын байдлаар Монгол Улсын хэмжээнд инфляцын түвшин 14.4 хувь, шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 6.5 хувь, системийн нөлөө бүхий Топ-5 банкны 18 сарын хугацаатай хадгаламжийн дундаж хүү 9.6 хувь байна.

Иймд хөрөнгө оруулагчид мөнгөний үнэ цэнийг алдагдуулахгүйгээр өгөөж хүртэхийн тулд 14.4 хувиас дээш түвшинд хөрөнгө оруулалт хийх шаардлага үүсээд байна. Симпл ХБҮЦ-ны хүү болох 15.0 хувь нь хөрөнгө оруулагчдыг инфляцын эрсдэлээс хамгаалах түвшинд байна.

*Зураг 18. Инфляц ба хадгаламжийн хүүний түвшин, хувиар*




*Эх сурвалж: Монголбанк*

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

## Банкны хадгаламжтай харьцуулахад

2022 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар банкны системийн нөлөө бүхий топ-5 банкны 18 сарын хугацаатай хадгаламжийн хүү 9.0-10.1 хувийн түвшинд хэлбэлзэж, дунджаар 9.6 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Симпл ХБҮЦ-ны хүүний түвшин нь тус дундаж хүүнээс 5.4 нэгж хувиар буюу 1.6 дахин өндөр байна.

***Зураг 19. Системийн нөлөө бүхий топ-5 банкны хадгаламжийн хүү, хувиар***




***Эх сурвалж: Банкуудын цахим хуудас***

## ХБҮЦ болон нээлттэй бондтой харьцуулахад

Үнэт цаасны танилцуулга бэлтгэх өдрийн байдлаар Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй хүрээнд Инвескор ББСБ ХК, ЛэндМН ББСБ ХК, МобиФинанс ББСБ ХХК болон Эрдэнэс Тавантолгой ТӨХК-ийн бонд, Инвескор Актив ТЗК ХХК болон Омни Актив ТЗК ХХК-ийн ХБҮЦ арилжаалагдаж байна.

Үүнээс дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй нээлттэй бондын дундаж хүүний түвшин 12.8 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Симпл ХБҮЦ-ны хүүний түвшин нь нээлттэй бондын дундаж хүүнээс 2.2 нэгж хувиар буюу 1.2 дахин өндөр байна.

Дотоодын хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй Инвескор Актив ХБҮЦ 14 хувь, Омни Актив ХБҮЦ 14.5 хувийн хүүтэй буюу зах зээл дэх ХБҮЦ-ны дундаж хүү 14.25 хувь байна. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Симпл ХБҮЦ-ны хүүний түвшин нь энэхүү дундаж хүүний түвшнээс 0.75 нэгж хувиар буюу 1.1 дахин өндөр байна.

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



*Зураг 20. Нээлттэй бонд ба ХБҮЦ-ны хүү, хувиар*




*Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж*

## 4.3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨГӨӨЖ

Симпл ХБҮЦ нь хөрөнгө оруулагч нарт үндсэн төлбөрийг 12 дахь сар болон хугацааны эцэст тэнцүү төлөлттэйгээр, хүүг улирал тутам олгохоор шийдвэрлэсэн нь үнэт цаасны хөрвөх чадвар, дахин хөрөнгө оруулалтын боломжийг нэмэгдүүлж байна.

*Хүснэгт 15. Өгөөжийн тооцоолол, төгрөгөөр*

| Улирал | Анхны хөрөнгө оруулалт | Хүүгийн орлого /татварын дараах/ | Үндсэн төлбөр хүлээн авах | Хугацааны эцэст хүү болон үндсэн төлөлт |
|---|---|---|---|---|
| **0** | **(100,000)** | | | |
| **1** | | 3,562.5 | | 3,562.5 |
| **2** | | 3,562.5 | | 3,562.5 |
| **3** | | 3,562.5 | | 3,562.5 |
| **4** | | 3,562.5 | 50,000.0 | 53,562.5 |
| **5** | | 1,781.3 | | 1,781.3 |
| **6** | | 1,781.3 | 50,000.0 | 51,781.3 |
| **Нийт** | (100,000) | **17,812.50** | **100,000.0** | **117,812.5** |

*Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол*

Үнэт цаасад хөрөнгө оруулагч нь 100 мянган төгрөгөөр 1 ширхэг ХБҮЦ-д хөрөнгө оруулалт хийсэн тохиолдолд үнэт цаасны хугацааны эцэст буюу 18 сарын дараа татварын дараах байдлаар 17.8 хувь өгөөж, 12 сарын дараа буюу жилийн түвшинд 14.25 хувийн өгөөж хүртэхээр байна.

УЛААНБААТАР ХОТ
УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS LLC

СЭХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

# 4.4 ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

## Төлбөрийн хуваарь, аргачлал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрийг тооцож олгоно. Үүнд анхдагч зах зээлийн захиалга амжилттай явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс эхлэн хүүг тооцож эхэлнэ. Үндсэн төлбөр болон хүүний төлөлтийг дараах аргачлалын дагуу хөрөнгө оруулагчид олгоно.

***Хүснэгт 16. Төлбөрийн хуваарь ба аргачлал***

| | |
|---|---|
| Хүү тооцож эхлэх хугацаа | Анхдагч зах зээлийн захиалга явагдаж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх өдрөөс хойш |
| Хүү төлөх давтамж | Улирал тутам |
| Хүүний төлбөр тооцох аргачлал (татварын өмнө) | $\frac{\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ} * (15\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар}$ |
| Хүүний төлбөр тооцох аргачлал (татварын дараа) | $\frac{\text{Тоо ширхэг} * \text{Нэрлэсэн үнэ} * (14.25\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар}$ |
| Үндсэн төлбөр төлөх давтамж | Үнэт цаасны хугацааны 12 дахь сард болон хугацааны эцэст тэнцүү төлөлттэй |
| Үндсэн төлбөр тооцох аргачлал | Үнэт цаас эзэмшиж эхэлсэн огноо + 12 сар /50%/<br>Үнэт цаас эзэмшиж эхэлсэн огноо + 18 сар /50%/ |
| Нийт төлөгдөх дүн | $\text{Үндсэн төлбөр I} + \frac{\text{Хүү тооцох дүн}^{1} * (14.25\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар} * 4 \text{ удаа}$<br>$\text{Үндсэн төлбөр II} + \frac{\text{Хүү тооцох дүн}^{2} * (14.25\%)}{12 \text{ сар}} * 3 \text{ сар} * 2 \text{ удаа}$ |

***Эх сурвалж: Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам***

## Төлбөрийн дараалал

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-н дагуу Үнэт цаас гаргагчийн төлбөр төлөх дараалал нь дараах байдалтай байна.

[1] Анхны хөрөнгө оруулалтын дүн

[2] Анхны хөрөнгө оруулалтын дүнгээс эхний үндсэн төлбөрийг хассан дүн

СЭХ
2022.06.08 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01




## Төлбөрийн график

***Хүснэгт 17. Төлбөрийн график, сая төгрөгөөр***

| Огноо | 0 улирал | I улирал | II улирал | III улирал | IV улирал | V улирал | VI улирал |
|---|---|---|---|---|---|---|---|
| Үнэт цаасны үлдэгдэл | 50,000 | 50,000 | 50,000 | 50,000 | 25,000 | 25,000 | - |
| Үндсэн төлбөрийн төлөлт | - | - | - | - | (25,000) | - | (25,000) |
| Хүүний төлбөрийн төлөлт | - | (1,890) | (1,870) | (1,849) | (1,890) | (945) | (935) |

***Эх сурвалж: Шинжээчийн тооцоолол***

Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжүүлсэн 50.0 тэрбум төгрөгийн дүн бүхий цалингийн зээлийн багцаас орж ирэх зээлийн үндсэн төлбөр болон хүүний төлбөрөөс бүрдэнэ.

## 4.5 ХӨРӨНГИЙН БАГЦЫН ТУХАЙ

Симпл ХБҮЦ-ны хөрөнгөд 10,236 зээлдэгчийн 50,001,389,249 төгрөгийн үлдэгдэл бүхий 12,780 зээлийн гэрээг багцалсан болно.

***Хүснэгт 19. Багцын тойм***

| Багцын үндсэн үзүүлэлтүүд | |
|---|---|
| Нийт зээлийн үлдэгдэл, төгрөг | 50,001,389,249 |
| Нийт анх олгосон дүн, төгрөг | 57,727,350,001 |

| | |
|---|---|
| Зээлийн гэрээний тоо | 12,780 |
| Зээлдэгчийн тоо | 10,236 |
| Зээлийн дундаж үлдэгдэл, мян.төгрөг | 3,912,472 |
| Зээлийн төрөл | Цалингийн зээл |
| **Зээлийн төвлөрөл** | |
| Хамгийн их дүнтэй 1 зээлийн нийт багцад эзлэх хувь | 0.04% |
| Хамгийн их дүнтэй 10 зээлийн нийт багцад эзлэх хувь | 0.40% |
| Хамгийн их дүнтэй 50 зээлийн нийт багцад эзлэх хувь | 1.98% |
| **Жигнэсэн дундаж үзүүлэлт** | |
| Жигнэсэн дундаж хүү /сар/ | 2.03% |
| Жигнэсэн дундаж зээлийн анхны хугацаа /сар/ | 23.3 |
| Жигнэсэн дундаж зээлийн үлдсэн хугацаа /сар/ | 19.3 |
| Багцын зээлийн чанар | 100% хэвийн зээл |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл*

## Зээлийн багцын шалгуур

Симпл ХБҮЦ-ны зээлийн багц нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангасан байна.

***Хүснэгт 20. Хуулийн шаардлага хангасан байдал***

| Хуулийн заалт | Хангагдсан эсэх |
|---|---|
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр нь хөрөнгийн багцыг бүрдүүлнэ | Үнэт цаас гаргагч 50 тэрбум төгрөгийн дүнтэй үнэт цаасыг, 50 тэрбум төгрөгийн үлдэгдэл бүхий зээлийн багцаар баталгаажуулсан. |
| Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үед үнэт цаас гаргагчийн эзэмшилд байх бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө байна. | Зээлийн багц нь гэрээний үндсэн дээр Симпл Ассет ТЗК руу бүрэн шилжсэн. |
| Хөрөнгийн багцад дараахь хөрөнгийг оруулахыг хориглоно:<br>- дуусаагүй барилга, сул чөлөөтэй газрын барьцаа;<br>- зээл болон барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь хуульд заасан эрх бүхий этгээдээс тогтоосон хэмжээнээс хэтэрсэн барьцаат зээл;<br>- хугацаа хэтэрсэн хөрөнгө | Зээлийн багц нь 100 хувь хэвийн ангилалтай цалингийн зээлийн хөрөнгөөс бүрдсэн. |

*Эх сурвалж: : Үнэт цаас гаргагчийн мэдээлэл*

Симпл ХБҮЦ-ны зээлийн багцын шалгуур үзүүлэлтийг Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан. Зээлийн багцыг санхүүгийн болон хуулийн шалгуур үзүүлэлтийн дагуу нийт зээлийн багцаас сонгон шалгаруулж, зээлийн шинжилгээ гаргагч Шонхор Үнэлгээ Аудит ХХК болон хуулийн дүгнэлт гаргагч Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН-ээр хөндлөнгийн дүгнэлт гаргуулсан.

### Зээлийн хөрөнгөд тавигдсан шалгуур

- Тасалбар болгох өдрөөр хэвийн ангилагдсан зээл байх
- Зээлийн хүү хамгийн багадаа жилийн 15.6 хувиас доошгүй байх
- Нэг зээлдэгчид олгосон зээлийн хэмжээ 20.0 сая төгрөгөөс ихгүй байх
- Зээлийг төгрөгөөр олгож эргүүлэн төлөхөөр байх
- Зээлийн хугацаа хамгийн багадаа 3 сараас доошгүй байх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгчид ямар ч төрлийн аливаа төлөх төлбөр, үүрэг хүлээгээгүй байх
- Хууль зүйн хувьд Анхны Үүрэг Гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд, тухайн зээлийн гэрээгээр бусад этгээдэд давхар үүрэг хүлээгээгүй байх
- Төлөлт нь бүрэн хорогдох байдлаар

### Зээлдэгчид тавигдсан шалгуур

- Эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн Монгол улсын иргэн байх
- Зээл олгох үед сүүлийн 6 сар тасралтгүй ажил, хөдөлмөр эрхэлсэн байх
- Зээл олгох үед банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байх
- Зээлдэгч Ипотекийн зээлтэй нөхцөлд татварын өмнөх орлогоос өр/орлогын харьцааг тооцно. Өр/орлогын харьцаа 60 хувиас ихгүй, ипотекийн зээлгүй тохиолдолд татварын дараах орлогоос тооцсон өр/орлогын харьцаа 80 хувиас ихгүй байх

### Зээлийн шинжилгээ гаргагчийн дүгнэлт

Шонхор Үнэлгээ Аудит ХХК нь шалгуурын дагуу сонгогдсон зээлийн багцад багтах зээлүүдээс түүвэрлэж, түүвэрт орсон зээлүүд нь санхүүгийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд шинжилгээ хийсэн. Шинжилгээний үр дүнд санамсаргүй түүврийн аргаар сонгон авсан 50 зээлийн зээлдэгчийн хувийн хэрэг, цахим зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга, Төрийн цахим мэдээллийн сангийн лавлагаа, Зээлийн мэдээллийн сан зэрэг мэдээллийг шалгасны үр дүнгээр бүх шалгуурыг хангаж байгаа гэж дүгнэсэн.

### Хөндлөнгийн хуулийн дүгнэлт

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь хэрэглээний зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээлийн данснуудаас санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон зээлийн данснуудад хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ хийж гүйцэтгэж, тус шинжилгээний үр дүнгээр санамсаргүй сонгогдсон 50 (тавин) зээлийн данснуудаас зээлийн хөрөнгө болон зээлдэгчид тавигдах хуулийн шаардлага хангаагүй эрсдэлтэй гэж үзсэн зээлийн данс илрээгүй гэж дүгнэсэн.

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2022-06-16
БҮРТГЭВ-03

## Зээлийн багцын төвлөрөл

*Хүснэгт 18. Зээлийн багц, дүнгээр*

| Анх олгосон дүн | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн (сая.төг) | % |
| 0 – 5.0 сая | 10,307 | 80.6% | 27,848 | 55.7% |
| 5.0 – 10.0 сая | 1,788 | 14.0% | 12,454 | 24.9% |
| 10.0 – 15.0 сая | 438 | 3.4% | 5,385 | 10.8% |
| 15.0 – 20.0 сая | 247 | 1.9% | 4,315 | 8.6% |
| **Нийт** | **12,780** | **100.0%** | **50,001** | **100.0%** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл*

Симпл ХБҮЦ-ны зээлийн багцад хамгийн их дүнтэй зээл 0.04 хувь, хамгийн их дүнтэй 10 зээл 0.4 хувь, хамгийн их дүнтэй 50 зээл 2.0 хувийг тус тус эзэлж буй нь зээлийн багцын төвлөрөл бага болохыг харуулж байна.

Зээлийн багцад шалгуурын дагуу зөвхөн 20.0 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй цалингийн зээл багтсан. Үүнд хамгийн бага дүнтэй нь анх 1.5 сая төгрөгөөр олгогдсон зээл байна. Нийт багцад багтсан 12,780 зээлийн 10,307 буюу 80.6 хувь нь 5.0 сая төгрөгөөс доош дүнтэй, 14.0 хувь нь 5.0-10.0 сая төгрөг, 3.4 хувь нь 10.0-15.0 сая төгрөг, 1.9 хувь нь 15.0-20.0 сая төгрөгийн үнийн дүнтэй зээл байна.

## Зээлийн багцын хугацаа

*Хүснэгт 19. Зээлийн багц, хугацаагаар*

| Зээлийн анхны хугацаа (сар) | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн (сая.төг) | % |
| 3 - 6 | 62 | 0.5% | 148 | 0.3% |
| 7 - 9 | 79 | 0.6% | 230 | 0.5% |
| 10 - 12 | 364 | 2.8% | 1,011 | 2.0% |
| 13 - 15 | 200 | 1.6% | 630 | 1.3% |
| 16 - 18 | 259 | 2.0% | 833 | 1.7% |
| 19 - 21 | 203 | 1.6% | 691 | 1.4% |
| 22 - 24 | 11,613 | 90.9% | 46,458 | 92.9% |
| **Нийт** | **12,780** | **100.0%** | **50,001** | **100.0%** |

*Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл*

Зээлийн шалгуурын дагуу зээлийн багцад 3-24 сар хүртэлх хугацаатай цалингийн зээл багтсан. Тодруулбал багцын зээлийн дүнгийн 94.3 хувь нь 19-24 сарын хугацаатай зээл байна. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хугацаа нь 18 сарын хугацаатайгаар зах зээлд нийлүүлэгдэж байгаа тул багцын хөрөнгийн хугацаатай уялдаатай байх нь зээлийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгал болон үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрт төлөгдөн гарах мөнгөн урсгалтай нийцэж байх, улмаар хөрвөх чадварын эрсдэлээс сэргийлдэг. Зээлийн багцын жигнэсэн дундаж хугацаа 23.3 сар байгаа нь үнэт цаасны

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS

хугацаа болох 18 сараас урт хугацаатай буюу үнэт цаасны хугацааны турш үндсэн болон хүүний төлбөрийг төлөх мөнгөн урсгал хангагдах боломжтойг илэрхийлж байна.

## Зээл олгогдсон огноо

***Хүснэгт 20. Зээлийн багц, улирлаар***

| Анх олгосон огноо | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| 2021 I | 50 | 0.4% | 178 | 0.4% |
| 2021 II | 362 | 2.8% | 1,426 | 2.9% |
| 2021 III | 1,361 | 10.6% | 5,254 | 10.5% |
| 2021 IV | 3,872 | 30.3% | 15,458 | 30.9% |
| 2022 I | 7,135 | 55.8% | 27,685 | 55.4% |
| **Нийт** | **12,780** | **100.0%** | **50,001** | **100.0%** |

***Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл***

Зээлийн багцын 55.8 хувь нь 2022 оны эхний улиралд олгогдсон зээл, үлдсэн 44.2 хувь нь 2021 онд олгогдсон зээл байна. Нийт зээлийн багцын 86.1 хувь нь сүүлийн 6 сард олгогдсон буюу шинэ зээлүүд байна.

## Зээлийн хүүний түвшин

***Хүснэгт 21. Зээлийн багц, хүүний түвшнээр***

| Хүүгийн тархалт | Зээлийн тоо | | Анх олгосон дүн | |
|---|---|---|---|---|
| | Тоо | % | Дүн | % |
| 1.0% - 1.5% | 1,344 | 10.5% | 6,152 | 12.3% |
| 1.5% - 2.0% | 3,264 | 25.5% | 15,086 | 30.2% |
| 2.0% - 2.5% | 6,759 | 52.9% | 25,103 | 50.2% |
| 2.5% - 2.9% | 1,413 | 11.1% | 3,659 | 7.3% |
| **Нийт** | **12,780** | **100.0%** | **50,001** | **100.0%** |

***Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн багцын мэдээлэл***

Зээлийн багцын шалгуурын дагуу сонгогдсон зээлийн хүүний түвшин хамгийн багадаа сарын 1.3 хувь байхаар тогтоогдсон. Багцад багтсан зээлийн хамгийн өндөр зээлийн хүү сарын 2.9 хувь, жигнэсэн дундаж хүү сарын 2.03 хувь байна. Зээлийн багцын жигнэсэн хүү 2021 оны салбарын зээлийн жигнэсэн дундаж хүү болох 2.7 хувиас 0.67 нэгж хувиар бага байна.

Нийт цалингийн зээлийн багцын дүнгийн 50.2 хувь нь сарын 2.0-2.5 хувь, 30.2 хувь нь сарын 1.5-2.0 хувь, 12.3 хувь нь сарын 1.3-1.5 хувь, үлдсэн 7.3 хувь нь сарын 2.5-2.9 хувийн хүүтэй зээл байна. Үнэт цаас гаргагчийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны сарын хүү 1.25 хувь буюу хөрөнгийн багцын зээлийн жигнэсэн дундаж хүү болох 2.03 хувиас бага байна. Энэ нь зээлийн хүүний орлого нь үнэт цаасны хүүний төлбөрийг төлөхөд хүрэлцээтэй болохыг харуулж байна.

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



### Зээлийн чанар

Зээлийн багц нь 100 хувь хэвийн зээлээс бүрдсэн байх шалгуур үзүүлэлтийг тавьсан. Иймд багцад байгаа бүх зээл нь хэвийн ангилалтай буюу зээлийн чанар сайн байна.

### Багцын дүгнэлт

Зээлийн багцын дүнгийн 92.9 хувийг 22-24 сарын хугацаатай, 55.7 хувийг 0-5 сая төгрөгөөр олгогдсон зээл эзэлж байна. Үүнээс дүгнэхэд зээлийн багцын дийлэнх нь урт хугацаатай, бага дүнтэй, төвлөрөл багатай зээл байна. Зээлийн багц нь 100 хувь хэвийн ангилалтай цалингийн зээлээс бүрдсэн.

## 4.6 ХӨРӨНГИЙН БАГЦАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-д заасан дараах үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.

Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, хөрөнгийн /зээлийн/ багцад байгаа хөрөнгийг багцаас хасаж солино. Үүнд:

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагчаас үзсэн;
- Зээлдэгч зээлийн үүргээ биелүүлэх боломжгүй болсон (тухайлбал нас барсан, сураггүй алга болсон, зээлтэй холбоотой асуудлаар шүүхэд маргаан үүссэн, зээлдэгч нь залилан мэхлэх арга замаар зээл авсан байж болзошгүй, цагдаагийн байгууллагад гомдол гаргасан гэх мэт);
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хөрөнгө худалдах худалдан авах гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ББСБ

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
9022040647

MANDAL CAPITAL MARKETS LLC

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нэлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн шаардлагаар.

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

## 4.7 АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧЭЭС ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн хувьд Үнэт цаас гаргагч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нартай байгуулсан Үйлчилгээний гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн хувиар зээлийн хөрөнгийн багцад үйлчилгээ үзүүлж, удирдана.

Ашид Капитал ББСБ ХХК-ийн Simple Аппликейшн нь харилцагч бүрд дахин давтагдашгүй бүртгэлийн дугаарыг үүсгэдэг. Тус бүртгэлийн дугаар нь зээлдэгчийн овог, нэр, регистерийн дугаар, нас, хүйс, орлого зэрэг хувийн мэдээллийн нууцлалын үүрэгтэй байдаг. Хэрэв харилцагч нь зээл авсан тохиолдолд харилцагчид зээлийн дансны дугаар үүсэх бөгөөд харилцагчийн зээлийн эрхийн дүнг хиймэл оюун ухаанд суурилсан кредит скорингийн системийн аргачлалаар тодорхойлогдоно. Тогтоосон хязгаар дотроо харилцагч хэд хэдэн удаа эсхүл нэг дор хэд хэдэн тооны зээл авах боломжтой. Энэ бүрд харилцагчид тус тусад нь зээлийн дансны дугаар үүсч зээл олгох зарчмаар ажиллана.

Зээлдэгчийн зээлийн мэдээлэл Ашид Капитал ББСБ ХХК-ийн хөгжүүлсэн программ хангамжийн хүрээнд бүрэн нууцлагдсан байдаг тул зээлийн хяналт, эргэн төлөлтийн үйл ажиллагааг зөвхөн Simple платформын нөхцлүүдийн стандартын шаардлагыг хангасан програмаар гүйцэтгэх боломжтой. Энэ бүх дотоод процесс нь автоматжуулсан байдаг.

Харилцагчид зээлийн лимит үүсгэн кредит скоринг хийх процесс нь харилцагч тус бүрийн санхүүгийн чадавхийн үзүүлэлтүүд дээр суурилж хийгддэг бөгөөд харилцагч зээлийн

ерөнхий гэрээ байгуулснаар тухайн зээлийн мэдээлэл нь их өгөгдөл байдлаар харилцагчийн кодлол бүхий мэдээлэлд түүх нэмэгдэх зарчмаар хувийн хэргийн өгөгдлийн системийг бий болгодог.

Тухайн харилцагчийн зээлийн төлбөр төлөлт, зээлтэй холбоотой эргэн хяналт, зээлийн хугацаан дахь тооцоолол зэрэг бүхий л үйл ажиллагаа нь өмнө үүсгэсэн их өгөгдөл дэх тухайн харилцагчийн мэдээлэл дээр тулгуурлаж хиймэл оюун ухаан, дотоод процесс автоматжуулах зарчмаар хийгддэг.

Ашид Капитал ББСБ ХХК-ийн энэхүү Simple платформыг хөгжүүлэгчид нь мэдээллийн технологи, банк санхүү, финтекийн чиглэлээр дотоодын болон олон улсын зах зээлд ажиллаж байсан туршлагатай багаас бүрддэг. Тус баг нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үүднээс ISO 27001: 2013 стандартыг дотоод үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Simple аппликейшн нь зээлдэгч бүрд эргэн төлөх өдөр зээл төлөх дүн, заавар бүхий мессеж болон аппликейшний мэдэгдэл илгээснээр эргэн төлөлтийн хугацаа хойшлох эрсдэлээс сэргийлдэг. Харилцагч зээлийн эргэн төлөлтийг өөрт тохирсон банкны шилжүүлэг, QPay эсвэл Socialpay хувилбаруудаас сонголтоо хийж зээлийг төлдөг. Зээлдэгч заврын дагуу зээлээ төлсөн тохиолдолд арилжааны банкуудын corporate-gateway хариу мэдээллийг автоматаар хөрвүүлж ямар зээлдэгч аль зээлийг ямар дүнгээр төлсөн талаарх мэдээллийг ашиглан үндсэн бүртгэлийн системд холбогдох санхүүгийн гүйлгээг мөн автоматаар хийдэг. Харилцагч тодорхой шалтгааны улмаас зээлээ төлөхөө мартсан, хугацаа хэтэрсэн үед системээс автоматаар зээлээ төлөх талаар мэдэгдэл илгээж, дахин зээл авах боломж нь хаагддаг.

Зээлийн эргэн төлөлт, харилцагчдын төлбөр цуглуулах үйл ажиллагааг хариуцсан нэгж нь эрсдэлийн удирдлагын хэлтсийн тусгай активын алба байна. Тус албаны удирдлага нь банк санхүүгийн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай. Үүнд хууль, өр барагдуулах чиглэлээр мэргэшсэн 10 мэргэжилтэн тус нэгжид ажиллаж байна.

Зээлдэгч төлбөрийн чадваргүй болох, төлбөрийн үүргээ биелүүлэхгүй болсон тохиолдолд үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс эрсдэлийн сан байгуулах, эрсдэлийн 3 талт удирдлагын үйл ажиллагаа хэрэгжүүлж үнэт цаас эзэмшигчийг эрсдэлээс хамгаална.

## 4.8 ТАТАН БУУГДАХ НӨХЦӨЛ

Симпл Ассет ТЗК ХХК-ийн компанийн дүрмийн 8 дугаар зүйлд зааснаар ТЗК нь дараах үндэслэлээр татан буугдана.

1. Баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн;
2. Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч буцаан худалдан авсан
3. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан.

ТЗК-ийг татан буулгах шийдвэрийг гаргах этгээд нь тусгай зориулалтын компани/1/ эсхүл үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлэгч/2/ эсхүл СЗХ-ны хүсэлтийг үндэслэн шүүх/3/ байна.

## 4.9 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаасжуулах ажиллагаанаас үүдэлтэй зээлийн хөрөнгийн багцын эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны төлбөр төлөгдөхгүй байх эрсдэл, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлого тасалдах эрсдэл бий болж болзошгүй байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 03 тоот тогтоолоор “Эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын журам”-ыг баталсан.

Тус журамд ТЗК-ийн ХБҮЦ гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан байна. Үнэт цаасжуулах үйл ажиллагааны хүрээнд дараах эрсдэлүүд учирч болзошгүй. Үүнд:

- Зээлтэй холбоотой эрсдэл
- Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл
  - Анхны үүрэг гүйцэтгүүлэгч
  - Үйлчилгээ үзүүлэгч
  - Хөрөнгө итгэмжлэн удирдагч
- Бусад гадны хүчин зүйлстэй холбоотой эрсдэл
  - Хууль, журам, зохицуулалт
  - Давагдашгүй хүчин зүйлс

**Зээлтэй холбоотой эрсдэл**

- Зээлийн эрсдэлд зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор

биелүүлээгүй улмаас үүсэх эрсдэлийг хэлнэ. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон байхыг ойлгоно.

- Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэлд зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө төлөх буюу хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдахыг ойлгоно.

**Зээлтэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- ТЗК нь зээлтэй холбоотой эрсдэлийг СЗХ-с баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам"-г мөрдөж, зээлийг ангилж, эрсдэлийн сан байгуулж ажиллана.
- Эрсдэлийн сан байгуулах ТЗК нь хагас жил тутамд зээлийн эрсдэлийн санг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) 9-н дагуу тооцож, холбогдох эрсдэлийн сангийн тохируулгыг хийнэ.
- ТЗК нь хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч талаас зээлийг эргэн төлүүлэхтэй холбоотой үйлчилгээ үзүүлэгчийн дотооддоо мөрдөж буй холбогдох заавар журмын хүрээнд үйлчилгээг авч, хяналт тавьж ажиллана. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.
- ТЗК нь зээл хугацаагаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх замаар арга хэмжээ авна.

## Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл**

- Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө ТЗК-ийн Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлэх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг сольж нэмж чадахгүй болох
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдах эрсдэлийг ойлгоно.

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- Хөрөнгийн багцыг шилжүүлэхээс өмнө ТЗК-ийн "Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам"-н 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг шаардах, ТЗК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд барьцаа хөрөнгөөр бусад төлбөр авагч нараас тэргүүн ээлжинд үүргийн гүйцэтгэлийг хангуулах ба барьцаа хөрөнгө нь шаардлагыг хангахгүй бол Иргэний хууль, Компанийн тухай хуульд заасан дараалаар хангана. Хэрэв Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дампуурсан тохиолдолд Дампуурлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.7-д заасны дагуу барьцаа

СЭХ
он сар өдөр
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

simple asset

хөрөнгөөр бусад нэхэмжлэгч нараас тэргүүн ээлжинд шаардлагыг хангах ба хэрэв барьцаа хөрөнгө нь шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол ийнхүү хүрээгүй хэсгийг энгийн нэхэмжлэлийн дараалаар хангана.

- ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан.

**Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл**

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх
- Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хорооноос цуцлах
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.

**Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана.
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр цуглуулах үйл ажиллагааг цаг хугацааны дагуу, бүрэн гүйцэд цуглуулах үүргээ санаатай буюу болгоомжгүй үйлдлийн улмаас зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.9 дэх хэсэгт заасны дагуу хохирлыг арилгана. Үйлчилгээ үзүүлэгч нь учруулсан хохиролтой тэнцэх хэмжээний мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.
- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.
- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.
- ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХЗК
67

MANDAL CAPITAL MARKETS ҮЦК ХХК

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-15
БҮРТГЭВ-03

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл**

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.

**Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийн удирдлага**

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашиглах тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.

ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан. Хөрөнгө итгэмжлэн удирдагч компани нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч компаниудтай ашиг сонирхлын зөрчилгүй болно. Түүнчлэн ХБҮЦ нь олон тооны бага дүнтэй зээлээс бүрдсэн тул зээлийн багцын орох урсгал болон үнэт цаасны төлөлтийг хяналтыг Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь програм ашиглан өдөр тутам хэрэгжүүлнэ.

**Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл**

- ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам, зохицуулалт өөрчлөгдөх эрсдэлийг ойлгоно.

**Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэлийн удирдлага**

- ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.
- Давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой эрсдэлд дараах арга хэмжээг авч ажиллана.
    - Давагдашгүй хүчин зүйл бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, ТЗК болон Биржийн цахим хуудсаар мэдээлнэ. Тухайн мэдэгдэлд учирсан давагдашгүй хүчин зүйлийг,

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
СИМПЛ АССЕТ ХХК
МАНДАЛ CAPITAL MARKETS ҮЦК LLC

түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээг, давагдашгүй хүчин зүйлийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна.

- Давагдашгүй хүчин зүйлийн улмаас ТЗК нь Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй нь хариуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөх ч үндсэн үүргээс чөлөөлөхгүй. Давагдашгүй хүчин зүйлийн үед ТЗК ийн үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

**Эргэн төлөлтийг сайжруулах**

ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээг авна.

- Багцын хөрөнгийг сайжруулах, солино.
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана.
- Багцын хөрөнгийн дүнг үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй дүнгийн 110 хувиас багагүй байлгана.
- Эрсдэлийн сан байгуулна.
- Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад нь ангид байлгана.
- ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба эрсдэлийн удирдлага, дотоод хяналтынжурмын 3.3.6 дугаар зүйлийн 3.3.6.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулна.
- ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлнэ.
- ТЗК нь татан буугдах үед зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

СЭХ
2022.06.08
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

simple | asset

# ТАВ. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 5.1 ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчтай холбоотой үйл ажиллагаа нь хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна Үүнд:

- Иргэний хууль
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Компанийн тухай хууль
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- Зээлийн мэдээллийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль

**Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд**

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
- Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам
- Үнэт цаас зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам
- Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам

**Монголын Хөрөнгийн биржийн журмууд**

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлийн журам
- Арилжааны журам

**Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн журмууд**

- Үнэт цаасны хадгаламжийн журам
- Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журам

**Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтууд**

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа нь Банк бус санхүүгийн байгууллага болохын хувьд хууль эрх зүйн орчны хувьд дараах хууль тогтоомжуудаар зохицуулагдаж байна.

- Монгол улсын үндсэн хууль
- Монгол улсын Олон гэрээ конвенцийг соёрхон батлах тухай /Монгол Улс 2001 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай олон улсын Конвенц/

- Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох хүн , ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар болон агаараар хууль бусаар оруулахын эсрэг протокол, шилжин суурьшигчдыг газраар, далайгаар, болон агаараар хууль бусаар тээвэрлэх, үйлдвэрлэхийн эсрэг протоколд нэгдэн орсныг соёрхон батлах туай /Палермогийн конвенц/
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
- Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам
- Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам
- Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт хийх журам
- Ашид Капитал ББСБ ХХК-ийн бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл

**Хөрөнгийн багцтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд**

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 1.1-д "Энэ хуулийн зорилт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж тодорхойлсон байдаг.

Дээрхээс үзвэл Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, түүнийг гаргагчтай холбоотой эрх зүйн үндсийг тогтож байгаа эрх зүйн гол баримт бичиг нь энэ хууль болох бөгөөд уг хуулиар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд танигдах шаардлага, хөрөнгийн багцад тавигдах шаардлага, баталгаат үнэт цаас гаргах харилцаанд оролцогч этгээдүүдийн хоорондын харилцаа, эрх үүрэг болон хөрөнгө оруулагчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтууд бүгд тусгагдсан байна. Дээрх хуульд үндэслэн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон, үнэт цаасыг бүртгэх үйл ажиллагааг зохицуулагч байгууллага болох СЗХ-оос гаргасан журмуудаар зохицуулж байна.

СЗХ-ны 2011 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам" -ын 1.1-д "Энэхүү журмын зорилго нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг СЗХ-нд бүртгэх,

түүнд хяналт тавих, зэх зээлийн харилцаанд оролцогчдод тусгай зөвшөөрөл олгох, шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох, эрх олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж заасан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох болон түүнийг бүртгэх, оролцогчдод тавих шалгуурыг тогтоох, эрх олгохтой холбоотой харилцааг тусгайлан зохицуулсан байна.

Мөн энэхүү журмаар Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч хуулийн этгээдтэй холбоотой Компанийн тухай хуулиар шийдвэрлэгдээгүй асуудлууд болох үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага зэргийг нарийвчлан зохицуулсан байна.

МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг тус биржийн бүртгэлд бүртгэх, Бүртгэлийн шалгуур шаардлага тогтоох, Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг, түүнд биржээс хяналт тавих журмыг тогтоосон байна.

## 5.2 ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ ДҮРЭМ ЖУРМУУД

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөх дараах журмуудыг Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр 03 тоот тогтоолоор баталсан.

**Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам**

Тус журамд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомж, зохицуулалтын байгууллагаас баталсан дүрэм, журам, стандартуудыг дагаж мөрдөх, үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх харилцааг зохицуулсан.

**Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам**

Тус журамд хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны талаар болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх, уг мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, нэгдсэн нэг мэдээллийн урсгалтай байх, түүнийг хэрэгжүүлэх, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулсан.

**Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих журам**

Тус журамд холбогдох этгээдүүдэд тавигдах шаардлага, шалгуур, гэрээ байгуулах, тэдгээрийг солих болон гэрээ цуцлахтай холбоотой харилцааг зохицуулсан.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам**

Тус журамд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотойгоор үүсгэн байгуулагдсан төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулсан.

**Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам**

Тус журамд ТЗК-аас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц дахь зээлүүдийн төлбөрийг цуглуулах, үнэт цаас эзэмшигчдэд үнэт цаасны төлбөр төлөхтэй холбоотойгоор ТЗК, Үйлчилгээ үзүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад холбогдох этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан.

**Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах журам**

Тус журамд компанийн гаргаж буй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны баталгаа болох зээлийн хөрөнгийн багцад буй хөрөнгийг солих, нэмэх, хасах замаар багцад өөрчлөлт оруулахтай холбоотойгоор Үнэт цаас гаргагчийн Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон бусад оролцогчтой холбоотой харилцааг зохицуулсан.

**Эрсдэл удирдлага, дотоод хяналтын журам**

Тус журамд ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль, журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг зохицуулсан.

СЗХ
2022 06 сар 0 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE

simple | asset

# ЗУРГАА. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03

simple asset

# 6.1 ҮНЭТ ЦААСНЫ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗАХИАЛГА ХҮЛЭЭН АВАХ ЗААВАР

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1 болон 12.2-т зөвхөн СЗХ-ны нийтэд санал болгохыг хүлээн зөвшөөрсөн, мөн МХБ-ийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг анхдагч зах зээлээр арилжихыг заасан байдаг.

Улмаар Симпл ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд гаргах арилжаа нь СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" (2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 2020/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан), мөн ТУЗ-ийн 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д (ТУЗ-ийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан) заасны дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь МХБ-ийн "ХБҮЦ-ны бүртгэлийн журам"-д заасан шалгуурын дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"-ийн 4.1.19-д заасан мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгчдийн хүрээнд ХБҮЦ-г санал болгон арилжаална. Тус үнэт цаасыг мэргэжлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэгч биш этгээд худалдан авч болно.

Симпл ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн захиалгыг зөвхөн тогтоосон үнээр буюу нэг үнийн түвшинд явуулах ба захиалгын дүн 40.0 тэрбум төгрөгт хүрсэн тохиолдолд арилжааг амжилттай болсонд тооцно. Үнэт цаасны захиалга татан төвлөрүүлэх дүнгээс давсан тохиолдолд захиалгыг цаг хугацааны дараалллаар 50.0 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлж болно. Уг тохиолдолд нэмэлтээр төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгасанчлан анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн санхүүжилтэд зарцуулна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг анхдагч зах зээлд дараах үйл явцын дагуу санал болгоно:

- ТЗК байгуулах
- Үнэт цаасыг эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх
- Олон нийтэд санал болгох
- Захиалгын бүртгэл хийх
- Захиалгыг баталгаажуулан үнэт цаасны нийлүүлэлт хийх
- Үнэт цаасыг эзэмшүүлж төлбөр тооцоог гүйцэтгэх
- Хоёрдогч арилжааг эхлүүлэх

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД БО ...
УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS

СЗХ
2022 .06 сар 6 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



## 6.2 ҮНЭТ ЦААСНЫ ЗАХИАЛГА ӨГӨХ ЗААВАР

Симпл ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн захиалгыг олон нийтэд санал болгохдоо андеррайтер төвтэйгээр зохион байгуулж байгаагаар онцлогтой. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга хүлээн авахдаа Монголын хөрөнгийн зах зээлд оролцогч бүхий л аж ахуй нэгж байгууллагуудын оролцоог тэгш хүртээмжтэй байхаар төлөвлөж, захиалга авах системийн ерөнхий зураглалыг боловсруулсан.

Анхдагч зах зээлийн захиалгыг дараах байдлаар байршуулах боломжтой.

1. Симпл аппликейшнээр захиалга байршуулах
2. Үнэт цаасны компаниар захиалга байршуулах

### Симпл аппликейшнээр захиалга байршуулах

1. Гар утсан дээрээ Симпл аппликейшнийг татаж бүртгүүлнэ. (Өлзий энд Ко капитал ҮЦК болон Мандал Капитал Маркетс ҮЦК дээр данстай эсэхийг автоматаар шалгана)
2. Үнэт цаасны дансгүй бол данс нээх хүсэлт илгээнэ. (Өлзий энд Ко капитал ҮЦК болон Мандал Капитал Маркетс ҮЦК дээр данс нээгдэнэ)
3. Данстай бол тухайн данстай ҮЦК-ийн нэрийг сонгож захиалга цэсрүү шилжинэ.
4. ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн захиалгыг байршуулна.
5. Үнэт цаасны данстай бол захиалга эхлэхээс өмнө дансаа QR/Deeplink ашиглан урьдчилж цэнэглэх боломжтой байна.
6. Захиалгын дүнг тооцож шилжүүлэх мөнгөн дүн болон шилжүүлгийн мэдээллийг боловсруулж, банкны аппликейшнтэй QR/Deeplink кодоор холбогдоно.
7. Банкны аппликейшний QR/Deeplink кодын мэдээллийн дагуу мөнгөн дүнг шилжүүлнэ.
8. Шилжүүлсэн мөнгөн дүнг захиалгын мөнгөн дүнтэй тулгаж анхдагч зах зээлийн захиалга баталгаажна.

### Үнэт цаасны компаниар захиалга байршуулах

ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаанд СЗХ-ноос зөвшөөрөл авсан, Монголын хөрөнгийн бирж-д бүртгэлтэй 54 үнэт цаасны компаниар дамжуулан оролцох боломжтой.

## 6.3 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

### Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаасны эзэмшигч нь дараах эрхтэй байна.

- Үнэт цаасыг биржийн арилжааны журмаар худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, шилжүүлэн авахыг шаардах
- Үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг тогтоосон хугацаанд хүлээн авах, төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах

ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК
СИМПЛ АССЕТ ХХК
MANDAL CAPITAL MARKETS LLC

- Үнэт цаас эзэмших эрхээ гуравдагч этгээдэд чөлөөтэй шилжүүлж, захиран зарцуулах, арилжаалах
- Үнэт цаас эзэмшиж буй хугацаандаа Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагааны талаар мэдээлэл хүлээн авах, мэдээллээр хангахыг шаардах
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулга болон гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах

## 6.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮҮРЭГ

ТЗК нь хөрөнгийг өмчлөх, бизнесийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх эсхүл шинээр эхлүүлэх болон ХБҮЦ гаргах баримт бичиг, хэлцлийн баримт бичгийн дагуу үүрэг хүлээх, эсхүл хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой, эсхүл тэдгээрийг зохицуулдаг бүх хууль, журам заавры́г бүх талаар дагаж мөрдөх үүрэгтэй.

- Үнэт цаасны үндсэн болон хүүний төлбөрийг төлбөр гүйцэтгэх хуваарийн дагуу бүрэн төлж барагдуулах;
- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу Үнэт цаасны хүүний орлогод ногдох татварыг суутган төсөвт төлөх, тайлагнах;
- Холбогдох гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг үл маргах журмаар төлж барагдуулах;
- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц мэдээллийг Үнэт цаас гаргагчийн " Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах журам"- заасны дагуу Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэх;
- Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад үүрэг.

## 6.5 ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧДЭД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ

Үнэт цаас гаргагч нь хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчид мэдээллээр хангах тал дээр ижил, тэгш хандах, үйл ажиллагаандаа нээлттэй, ил тод байх зарчмыг баримтлах ба хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчтэй харилцах, хууль тогтоомжийн дагуу тогтмол мэдээ, мэдээллийг хүргэх нөхцөлийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй.

Мэдээлэл хүргэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны "Үнэт цаас гарагчийн мэдээллийн ил тод байдлын журам", МХБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам" болон ТЗК-н ТУЗ-аас баталсан "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам"-д заасны дагуу мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэт мэдээллүүдийг үнэт цаас эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагч нь нь олон нийтэд хүргэх мэдээллийг нэгэн зэрэг сонирхогч бүх этгээдэд МХБ-ийн болон өөрийн цахим хуудсаар дамжуулан тогтоосон хугацаанд мэдээлнэ. Үнэт

цаас гаргагчийн цахим хуудсанд нийтэд тогтмол мэдээлэл хүргэх хэсэг байрших бөгөөд тус хэсгийн мэдээлэл нь ТЗК нь татан буугдах хүртэл хугацаанд байршина.

## Улирал тутам хүргүүлэх мэдээлэл

| | |
|---|---|
| Дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор<br>СЗХ болон МХБ-д цахимаар, Хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ. | - Төлбөр, зарлага, хөрөнгө оруулагчдад төлөх үнэт цаасны эргэн төлөлтөөс бусад хөрөнгө, хөрөнгө оруулалтаас олсон орлогын зарцуулалт<br>- Хөрөнгийн багцын нарийвчилсан мэдээлэл, тэдгээрийн байдал<br>- Хөрөнгийн багцад нэмэгдсэн, хасагдсан хөрөнгө, нэмэх хасах<br>- болсон үндэслэл, шалтгаан, үнэт цаасны жигнэсэн дундаж хүү, эргэн төлөгдөх нөхцөл, үлдэгдэл хөрөнгийн тоо хэмжээ,<br>- Төлөгдөөгүй хөрөнгийн үлдэгдэл болон үндсэн зээлийн<br>- харьцаа, төлөгдсөн үндсэн зээл, баталгаат үнэт цаасны үлдэгдэл, бэлэн мөнгөний төвлөрсөн хэмжээ, түүний ашиглалт;<br>- Санхүүгийн үзүүлэлт, тоо баримтууд, улирлын санхүүгийн<br>- тайлан;<br>- Хууль тогтоомж, энэхүү журам, ТЗК-ийн дүрэм, гэрээгээр<br>- хүлээсэн үүргийн дагуу мэдээлэх бусад мэдээлэл<br>- Жилийн үйл ажиллагааны тайлан |

## Хагас жил тутам хүргүүлэх мэдээлэл

| | |
|---|---|
| СЗХ болон МХБ-д бичгээр Хөрөнгө оруулагчдад МХБ-ийн болон компанийн цахим хуудсаар дамжуулан мэдээлнэ. | Хагас жилийн тайлан. Үүнд дараах мэдээллүүд багтсан байна:<br>- Хөрөнгийн багцын үлдэгдэл<br>- Хугацаандаа болон хугацаа хэтэрч төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ<br>- Хугацаанаас өмнө төлөгдсөн үндсэн төлбөрийн хэмжээ<br>- Ердийн шаардлагад нийцэхгүй болсон буюу хугацаа хэтэрсэн хөрөнгийн хэмжээ<br>- Хөрөнгө болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн нөхцөлд нөлөөлөхүйц бусад мэдээлэл |

## Жил тутам хүргүүлэх мэдээлэл

| | |
|---|---|
| СЗХ-д: Дараа оны 02 сарын 20-ны өдрийн дотор СЗХ болон Хөрөнгө оруулагчдад хүргэнэ.<br>МХБ-д: Дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэнэ | Жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан санхүүгийн тайлан. Үүнд дараах мэдээлэл багтсан байна:<br>- ТЗК-ийн болон түүний үүсгэн байгуулагчийн аудитын байгууллагаар баталгажсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт<br>- Үнэт цаасны танилцуулгад заасан хөрөнгийн удирдлагын стандарт, шалгуур<br>- Томоохон үүрэг гүйцэтгэгч, зээлийн баталгаа гаргагч сүүлийн тайлангаас гарсан баталгаат үнэт цаас болон үүсгэн байгуулагчид мэдэгдсэн мэдэгдэл, санхүүгийн баримтын талаарх мэдээлэл |

СЭХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01



- ТЗК-ийн ТУЗ-ийн үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл

## Өөрчлөлт гарсан тохиолдолд хүргүүлэх мэдээлэл

| | |
|---|---|
Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээг хэлцэлд оролцогч анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ирүүлсэн зээлийн хувийн хэрэг, түүнд авагдсан баримт материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээллийн хүрээнд, ББСБ-ын байранд хийж гүйцэтгэсэн бөгөөд хөндлөнгийн дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, хууль ёсны, жинхэнэ эх эсхүл жинхэнэ эхээс хуулбарлагдсан гэж үзэж, ашигласан болно.

Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан гаргахад ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд тухайн баримт бичиг, үйл баримтыг үнэлж, дүгнэсэн хугацаанаас хойш болон Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон байж болохыг анхаарна уу.

Үнэт цаас гаргагчийн хүсэлтийн дагуу Хуулийн фирм нь Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангийн талаар гуравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгч болно. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь ажлын даалгаварт тусгаснаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

Хөндлөнгийн дүн шинжилгээ хийх явцад техникийн шинжтэй буюу бүртгэлийн ажилтны санамсаргүй, хайхрамжгүй үүссэн алдаа болон зээлдэгчийн зээлийн хувийн хэрэг үүсгэх зорилгоор хувийн хэрэгт хавсаргасан мэдээлэл, баримт бичгийг дижитал хэлбэрээр төвлөрүүлсэн баримт бичгийг удирдлагын нэгдсэн сангийн бүртгэлд үүссэн зөрүүтэй мэдээллийг эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнээс нэмэлт тодруулга, мэдээллийг авч ажилласан болохыг дурдаж байна.

Хөндлөнгийн дүн шинжилгээ хийхэд ашигласан, энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангийн салшгүй хэсэгт тооцогдох түүвэрлэгдсэн зээлийн дансдын тоо болон шалгуур үзүүлэлтийг энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайланд хавсаргасан болно.

Хуулийн фирм нь зээлийн хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээлийн дансдаас санамсаргүй түүврийн аргаар сонгож авсан зээлийн дансдад Хөндлөнгийн дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн бөгөөд сонгогдсон зээлийн дансдын хувийн хэргийн бүрдүүлбэр материал, баримтад агуулагдсан дараах асуудлыг үнэн зөв, хууль ёсны гэж үзсэн учир хариуцлага хүлээхгүй болохыг дурдаж байна. Үүнд:

1. Хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээнд гарын үсэг зурсан ББСБ-аас эрх олгогдсон эрх бүхий албан тушаалтан болон зээлдэгч, тэдгээрийн төлөөлөгч нарын гарын үсэг нь үнэн зөв, жинхэнэ, хууль ёсны дагуу эрх олгогдсоны үндсэн дээр зурагдсан эсэх;
2. Зээлийн хувийн хэрэгт авагдсан болон авагдаагүй зээлийн гүйлгээний баримт, мемориалын баримт, зээлжих зэрэглэлийн үнэлгээний мэдээлэл, нөхцөл шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тооцоолсон зээлдэгчийн зээлийн үнэлгээний тайлан зэрэг санхүүгийн үр дагавар үүсгэх төлбөрийн тодорхойлолт, бусад адилтгах төлбөрийн баримт зэрэг санхүүгийн баримт нь үнэн зөв, үйлдэгдэх ёстой цаг хугацаандаа үйлдэгдсэн, хүчин төгөлдөр эсэх;

СЗХ
2022 .06 сар 8 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022 -06- 16
БҮРТГЭВ-03





3. Зээлдэгч зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн дансны хуулга, бусад адилтгах орлого тодорхойлох баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр баримт эсэх;
4. ББСБ болон зээлдэгч нарын хооронд аливаа холбоо хамаарал бий эсэх;
5. Зээлийн хувийн хэрэгт авагдсан ЗМС-ын мэдээлэл, Хүр систем-Нийгмийн даатгалын лавлагаа, баримт бичиг нь үнэн зөв, хууль ёсны, бүрэн, хүчин төгөлдөр эсэх;
6. Хэрэглээний зээл олгосноос хойш зээлдэгчийн ӨОХ нь зохих шаардлагыг хангасан эсэх;
7. Зээлийн хувийн хэрэгт байгаа хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, хэлцлийн үнэн зөвийг гэрчилсэн нотариатын үйлдэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр, хууль ёсны эсэх;
8. Түүврээр сонгогдсон зээлийн дансдаас бусад нийт хөрөнгийн багцыг бүрдүүлж буй зээлийн данстай холоотой аливаа асуудал;
9. Ажлын даалгавар нь ХЗХБҮЦ-ын ирээдүйн эрсдэлийг бүрэн хаасан, хангалттай тодорхойлогдсон эсэх зэрэг асуудал болно.

**Хөндлөнгийн дүн шинжилгээний ажлын зорилго**

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээ нь зөвхөн анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс худалдахаар санал болгож байгаа хэрэглээний зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зээлийн хөрөнгийн багцад анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргаж өгсөн шалгуур үзүүлэлтүүдийг бодитоор хангаж буй эсэхийг нийт зээлийн хөрөнгийн багцаас санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон дэд багцаар төлөөлүүлэн шалгаж, дүн шинжилгээ хийж энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг бэлтгэсэн.

**Хөндлөнгийн дүн шинжилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн хугацаа**

Хуулийн фирм нь Гэрээгээр тохиролцсон Хөндлөнгийн дүн шинжилгээг ББСБ-ын байранд 2022 оны 04 сарын 14-ны өдрөөс 2022 оны 04 сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

**Түүврээр сонгогдсон зээлийн дансдын мэдээлэл**

Хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ Гэрээгээр тохиролцсон ажлын даалгаварт заагдсаны дагуу нийт 50 (тавин) зээлийн дансыг сонгож авсан. Санамсаргүй түүврийн аргаар сонгож түүвэрлэлт хийхдээ дараах зарчмыг баримталсан. Үүнд:

(i) Түүврээр сонгогдсон багцын цалингийн зээл болон цалингийн зээл М-Си-Эс группын ажилчдад олгогдсон зээл нь нийт багцын бүтэцтэй ойролцоо байх;
(ii) Хамгийн өндөр дүнтэй зээлийн дансдыг сонгох;
(iii) Хамгийн урт хугацаатай зээлийн дансдыг сонгох.

Хуулийн фирмд ирүүлсэн жагсаалт дахь ББСБ-ын нийт 12,780 (арван хоёр мянга долоон зуун наян) ширхэг зээлийн дансдаас 50 (тавин) зээлийн дансдыг дээрх зарчмын дагуу түүвэрлэн авсан. Хөндлөнгийн дүн шинжилгээний хүрээнд түүвэрлэж авсан зээлийн дансдын бүтцийн хувьд авч үзвэл дараах байдлаар сонгож авсан. Үүнд:

*Хүснэгт №01. Түүврээр сонгогдсон зээлийн дансдын бүтэц, тоон үзүүлэлт*

| # | Хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн | Зээлийн тоо хэмжээ | Хувь хэмжээ | Зээлийн дүн | Хувь хэмжээ | Сонгогдсон зээлийн тоо |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Цалингийн зээл | 11,143 | 87% | 42,786,774,796 | 86% | 43 |
| 2. | Цалингийн зээл М-Си-Эс групп | 1,637 | 13% | 7,214,614,453 | 14% | 7 |
| | **Нийт** | **12,780** | **100%** | **50,001,389,249** | **100%** | **50** |

Хөндлөнгийн дүн шинжилгээнд түүвэрлэж авсан зээлийн дансдыг хэрэглээний зээлийн бүтээгдэхүүний хугацаагаар тооцож нийт багцын бүтэцтэй ойролцоо байхаар сонгож авсан. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК



MANDAL CAPITAL MARKETS SC LLC

СЗХ
2022.06сар08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-15
БҮРТГЭВ-03

НУУЦ БАРИМТ
**Эх хувь**

*Хүснэгт №02. Түүврээр сонгогдсон зээлийн дансдын зээлийн хугацааны дэлгэрэнгүй бүтэц, тоон үзүүлэлт*

| # | Хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн | 3-12 сар | 13-18 сар | 19-23 сар | 24 сар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Цалингийн зээл | 1 | 1 | 1 | 40 | 43 |
| 2. | Цалингийн зээл М-Си-Эс групп | - | - | - | 7 | 7 |
| Нийт | | 1 | 1 | 1 | 47 | 50 |

Хуулийн фирмийн зүгээс түүвэрлэн сонгосон зээлийн дансдын тоог Үнэт цаас гаргагчтай харилцан баталгаажуулсан болохыг мөн дурдаж байна.

**Хөндлөнгийн дүн шинжилгээ хийж гүйцэтгэсэн газар, бүрэлдэхүүн**

Түүврээр сонгогдсон зээлийн дансдад дүн шинжилгээ хийх ажлыг түүвэрт сонгогдсон зээлийн хөрөнгийн анхны үүрэг гүйцэтгүүлэгч ББСБ-аас зээлийн дансдын хувийн хэрэгт авагдсан баримт материалыг эх хувиар хүлээн авч, эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтнээс нэмэлт, мэдээлэл, тодруулга авч хийж гүйцэтгэсэн.

**Хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн аргачлал**

Хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэрэг, зээлийн дансдын материалыг бэлтгүүлэн эх хувиар хүлээн авч, Симпл Ассет ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 04 сарын 13-ны өдрийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангах тухай тогтоолын Хавсралт №1-р батлагдсан ХЗХБҮЦ-ны хэлцлийн хүрээнд худалдах хөрөнгийн багцад тавигдах шалгуур үзүүлэлт болон ББСБ-аас баталсан Бүтээгдэхүүн үйлчилгээний ерөнхий нөхцөл, дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримтад үндэслэн бэлтгэсэн нарийвчлан тогтоосон шалгуур үзүүлэлтээр шалгаж, үнэлэх замаар хийж гүйцэтгэлээ.

**Хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн арга зүй**

Хөндлөнгийн дүн шинжилгээг хийхдээ Гэрээгээр тохиролцсон ажлын даалгаварт тодорхойлсон зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур болон зээлдэгчид тавигдах үндсэн шалгуур үзүүлэлт, тэдгээр үзүүлэлтүүдийг нарийвчлан тохиролцсон шалгуур үзүүлэлтийн дагуу шалгасан. Хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ дараах хууль, эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болголоо. Үүнд:

1. Иргэний хууль (2002);
2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010);
3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль (2002);
4. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021);
5. Зээлийн мэдээллийн тухай хууль (2011);
6. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009);
7. Санхүүгийн зохицуулах хорооны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам (2001);
8. МХБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам (2020);
9. Ашид Капитал ББСБ-ын Бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл;
10. Бусад холбогдох хууль тогтоомжууд.

Хуулийн фирмээс нарийвчлан тодорхойлсон шалгуур асуултын дагуу ББСБ-ын сонгогдсон зээлийн дансдыг нэг бүрчлэн шалгасан бөгөөд данс тус бүр дээр шалгаж бөглөсөн шалгах хуудсанд тусгагдсан мэдээлэлд үндэслэн энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг бэлтгэсэн болно.

СЗХ
2022.06.08 сар ... өдөр
БҮРТГЭВ
№ 01



НУУЦ БАРИМТ
**Эх хувь**

Мөн нэмж дурдахад зээлийн дансдад дүн шинжилгээ хийж, Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан бэлтгэж байх хугацаанд зээлийн дансдын хувийн хэргийн холбогдох нэмэлт тайлбар, тодруулга, баримт материалыг ББСБ-д тухай бүр мэдэгдэж, нэмэлт баримт материалыг нягталж үзэх зарчмыг баримталсан бөгөөд холбогдох техникийн алдаа, зөрчлийг арилгасан дансдын хувьд шалгуур үзүүлэлтийг хангасан гэж үзэж явсан болохыг дурдаж байна.

*Хүснэгт 03. Хөрөнгийн багцад тавьсан шалгуур үзүүлэлт*

| # | Хэрэглээний зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зээлд тавигдсан хуулийн шаардлага |
|---|---|
| | **Нэг. Зээлийн хөрөнгөд тавигдах шалгуур** |
| 1. | *Дүн шинжилгээ хийх өдрөөр хэвийн ангилагдсан зээл байх;* |
| 2. | *Зээлийн хүү хамгийн багадаа жилийн 15.6 хувиас доошгүй байх* |
| 3. | *Зээлдэгчид олгосон зээлийн хэмжээ 20.0 сая төгрөгөөс ихгүй байх;* |
| 4. | *Зээлийг Монгол төгрөгөөр олгож эргүүлэн төлөхөөр байх;* |
| 5. | *Зээлийн хугацаа хамгийн багадаа 3 (гурван) сараас доошгүй байх;* |
| 6. | *Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгчид ямар ч төрлийн аливаа төлөх төлбөр, үүрэг хүлээлгээгүй байх;* |
| 7. | *Хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд, тухайн зээлийн гэрээгээр бусад этгээдэд давхар үүрэг хүлээлгээгүй байх;* |
| 8. | *Төлөлт нь бүрэн хорогдох байдлаар байх.* |
| | **Хоёр. Зээлдэгчид тавигдах шалгуур** |
| 9. | *Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх;* |
| 10. | *Зээлдэгч нь сүүлийн 6 (зургаан) сар тасралтгүй ажил, хөдөлмөр эрхэлсэн байх;* |
| 11. | *Зээл олгох үед банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байх;* |
| 12. | *Зээлдэгч ипотекийн зээлтэй нөхцөлд татварын өмнөх орлогоос ӨОХ-г тооцох бөгөөд ӨОХ 60 (жаран) хувиас ихгүй байх, ипотекийн зээлгүй тохиолдолд татварын дараах орлогоос тооцсон ӨОХ 80 (наян) хувиас ихгүй байх.* |

**Анхан шатны материал, дэлгэрэнгүй шалгуур бүхий хуудсыг хадгалах хугацаа**

Хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг бэлтгэх үндэслэл болсон анхан шатны материал буюу түүвэрлэгдсэн зээлийн данс тус бүр дээр бөглөгдсөн, дэлгэрэнгүй шалгуур асуултаар шалгаж тэмдэглэгдсэн баримт, Хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг хүлээлгэж өгсөн өдрөөс хойш хуанлийн 1 (нэг) жилийн хугацаанд Хуулийн фирм хадгална. Хадгалах хугацаа өнгөрснөөс хойш анхан шатны баримттай холбоотой аливаа шаардлагыг Хуулийн фирм хүлээж авахгүй болохыг анхаарна уу.

**Хөндлөнгийн дүн шинжилгээ, дүгнэлт**

Хуулийн фирм нь анхны үүрэг гүйцэтгүүлэгч Ашид Капитал ББСБ ХХК-ийн сонгогдсон зээлийн дансдын хувийн хэрэгт хөндлөнгийн дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дараах байдлаар дүгнэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

**Шалгуур 1. Хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар хэвийн ангилагдсан зээл байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь нийт сонгогдсон зээлийн дансдын хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар хувийн хэрэгт авагдсан зээлдэгчийн зээл, үнэлгээний тайлан, хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, зээл авах үеийн байдлаарх Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл болон дүн шинжилгээ хийх өдрийн байдлаарх зээлийн дансны хуулга дахь зээлийн үлдэгдэл хэмжээг нягталж шалгалаа.

Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээнд сонгогдсон нийт зээлийн данс нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар хэвийн ангилагдсан зээл байх шалгуурыг хангаж байна гэж дүгнэлээ.

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03





**Шалгуур 2. Зээлийн хүү хамгийн багадаа жилийн 15.6 хувиас доошгүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлдэгчийн хувийн хэрэг, түүнд авагдсан зээл олгохыг хүссэн өргөдөл, зээлдэгчийн зээл, үнэлгээний тайлан болон хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээнд тусгасан мэдээллийг нягталж үзлээ.

Иргэний хуулийн 282 дугаар зүйлд[1] зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болох бөгөөд хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр байгуулна, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7 дахь заалтад[2] зээлийн гэрээнд зээлийн хүүгийн хэмжээг тусгахаар тус тус зохицуулсан байна.

Сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэрэг, түүнд агуулагдсан цахим зээлийн гэрээ, баримт материалд үндэслэж үзвэл нийт сонгогдсон зээлийн дансдын зээлийн хүү хамгийн багадаа 15.6 хувиас доошгүй байх шалгуурыг хангаж байна гэж Хуулийн фирм дүгнэлээ.

**Шалгуур 3. Нэг зээлдэгчид олгосон зээлийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс ихгүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлдэгчийн хувийн хэрэг, түүнд авагдсан зээлдэгчийн зээл, үнэлгээний тайлан болон хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарь болон зээлийн гүйлгээний баримт болон ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөгддөг бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөлд тусгасан зээлийн хэмжээг нягталж үзлээ.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалтад[3] зээлийн гэрээнд

---

[1] **Иргэний хууль (2002).**
282 дугаар зүйл. **Зээлийн гэрээний хүү**
282.1 Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно
282.2 Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасгаж болно
282.3 Хуульд өөрөөр заагаагүй бол хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана.
*[illegible]*
282.4 Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулсанд тооцно
[2] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
20 дугаар зүйл **Зээлийн гэрээ**
20.2 Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна:
20.2.7 зээлийн хүүгийн хэмжээ.
Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009)
**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
3.1.1."Монгол Улсын нутаг дэвсгэр" гэж эдийн засгийн чөлөөт бүс, Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын байршлаас бусад Монгол Улсын газар нутгийг;
3.1.2."үндэсний мөнгөн тэмдэгт" гэж Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төлбөрийн хууль ёсны хэрэгсэл болох төгрөгийг хэлэх бөгөөд төгрөгийг англи хэл дээр "Togrog", товчлолыг "MNT" гэж бичнэ.
**4 дүгээр зүйл.Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ**
4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.
4.2.Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.
4.3.Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ.
4.4.Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно.
[3] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
20 дугаар зүйл **Зээлийн гэрээ**
20.2 Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна:
20.2.1 зээлийн хэмжээ.



УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ
Х135
MANDAL CAPITAL MARKETS LLC

СЭХ
2022.06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16
БҮРТГЭВ-03



зээлийн хэмжээг тусгахаар хуульчилсан байна. Түүнчлэн Ашид Капитал ББСБ ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй Бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөлд (i) цалингийн зээл; болон (ii) цалингийн зээл М-Си-Эс групп ангиллын зээлийн дээд хэмжээг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр тогтоож зохицуулсан байна.

Иймд сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэргийн баримт материалд үндэслэн дүгнэж үзвэл нийт сонгогдсон зээлийн дансдын цахим зээлийн гэрээнд зээлийн хэмжээг тусгасан байх бөгөөд зээлийн хэмжээ 20,000,000 (хорин сая) төгрөгөөс ихгүй байх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

**Шалгуур 4. Зээлийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр олгож, эргүүлэн төлөхөөр байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлдэгчийн хувийн хэрэг, түүнд авагдсан зээлдэгчийн зээл, үнэлгээний тайлан болон хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарь болон зээлийн гүйлгээний баримтад тусгасан мэдээллийг нягталж үзлээ.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтад[4] зээлийн гэрээнд мөнгөн тэмдэгтийг тусгахаар хуульчилсан байна.

Сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэргийн баримт материал, цахим зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарь болон зээлийн гүйлгээний баримтад үндэслэж үзвэл нийт

---

Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009).
**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
3.1.1."Монгол Улсын нутаг дэвсгэр" гэж эдийн засгийн чөлөөт бүс, Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын байршлаас бусад Монгол Улсын газар нутгийг;
3.1.2."үндэсний мөнгөн тэмдэгт" гэж Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төлбөрийн хууль ёсны хэрэгсэл болох төгрөгийг хэлэх бөгөөд төгрөгийг англи хэл дээр "Togrog", товчлолыг "MNT" гэж бичнэ.
**4 дүгээр зүйл.Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ**
4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.
4.2.Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.
4.3.Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ.
4.4.Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно.
[4] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
20 дугаар зүйл.**Зээлийн гэрээ**
20.2.Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна:
20.2.2.мөнгөн тэмдэгтийн төрөл.
**Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль (2009).**
**3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:
3.1.1."Монгол Улсын нутаг дэвсгэр" гэж эдийн засгийн чөлөөт бүс, Монгол Улсад байгаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын байршлаас бусад Монгол Улсын газар нутгийг;
3.1.2."үндэсний мөнгөн тэмдэгт" гэж Монголбанкнаас гүйлгээнд гаргасан төлбөрийн хууль ёсны хэрэгсэл болох төгрөгийг хэлэх бөгөөд төгрөгийг англи хэл дээр "Togrog", товчлолыг "MNT" гэж бичнэ.
**4 дүгээр зүйл.Үндэсний мөнгөн тэмдэгтийн хэрэглээ**
4.1.Бараа, ажил, үйлчилгээний үнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлж, түүгээр төлбөр тооцоог гүйцэтгэх ба энэ хуулийн 4.4-т зааснаас бусад тохиолдолд Монголбанкны албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх, зарлан сурталчлахыг хориглоно.
4.2.Улсын болон орон нутгийн төсөвт төлөх, төсвөөс санхүүжүүлэх аливаа төлбөр тооцоог зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх бөгөөд эдгээр төлбөр тооцоог гадаад валютаар гүйцэтгэхийг хориглоно.
4.3.Монгол Улсын хууль тогтоомжид хураамж, шимтгэл, хариуцлагын хэмжээг тодорхойлохдоо зөвхөн төгрөгөөр илэрхийлнэ.
4.4.Банк, банк бус санхүүгийн байгууллагын мөнгөн хадгаламж, зээл, тэдгээртэй адилтгах аливаа үйлчилгээ, санхүүгийн үүсмэл хэрэгсэлтэй холбоотой байгуулах гэрээ, түүгээр хүлээх үүргийг гадаад валютаар илэрхийлж, гүйцэтгэлийг гадаад валютаар хангуулж болно.



УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

сонгогдсон зээлийн дансдын зээлийг үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр олгож, эргүүлэн төлөхөөр тусгасан байх тул тус шалгуурыг хангасан байна гэж үзлээ.

**Шалгуур 5. Зээлийн хугацаа хамгийн багадаа 3 (гурван) сараас доошгүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлдэгчийн хувийн хэрэг, түүнд авагдсан зээлдэгчийн зээл, үнэлгээний тайлан болон хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт тусгасан мэдээллийг нягталж үзлээ.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад[5] зээлийн гэрээнд зээлийн хугацааг тусгахаар хуульчилсан байна.

Сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэргийн баримт материалд үндэслэн дүгнэж үзвэл нийт сонгогдсон зээлийн дансдын зээлийн гэрээнд зээлийн хугацааг тусгасан байх бөгөөд зээлийн хугацаа хамгийн багадаа 3 (гурван) сараас доошгүй байх шалгуурыг хангасан байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Шалгуур 6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгчид ямар ч төрлийн аливаа төлөх төлбөр, үүрэг хүлээгээгүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар зээлдэгчийн хувийн хэрэг, түүнд авагдсан баримт материал болон хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээр гэрээний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгчид төлөх мөнгөн хөрөнгийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн эсэхийг шалгалаа.

Хуулийн фирмийн зүгээс сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэрэг, түүнд авагдсан хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ, баримт материалд үндэслэж үзвэл хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ нь хүчин төгөлдөр бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлдэгчид гэрээний дагуу төлөх төлбөр, үүрэг хүлээсэн аливаа нөхцөл үүсээгүй байх тул нийт сонгогдсон зээлийн дансд нь тус шалгуурыг хангаж байна гэж үзсэн.

**Шалгуур 7. Хэрэглээний зээл нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд тухайн зээлийн гэрээгээр бусад этгээдэд давхар үүрэг хүлээгээгүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь нийт сонгогдсон зээлийн дансдын хэрэглээний зээл нь ББСБ-аас олгогдсон эсэх, хөндлөнгийн дүн шинжилгээ хийх үеийн байдлаар зээлийн хувийн хэрэг, түүнд агуулагдсан хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээ нь хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлага хангасан хуулийн хүчин төгөлдөр эсэх, хуульд заасан толооллийг хангасан эсэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч ББСБ болон зээлдэгчийн хооронд байгуулсан хэрэглээний зээлийн эрхийн гэрээ болон цахим зээлийн гэрээний дагуу гуравдагч этгээдэд худалдах, бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцэл (батлан даалт, барьцаа, баталгаа) хийсэн талаар зээлийн хувийн хэрэгт авагдсан эсэх, хэрэглээний зээлийн эрхийн гэрээ, цахим зээлийн гэрээнд бусад этгээдийн өмнө давхар үүрэг хүлээсэн эсэхийг шалгалаа.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Банк, эрх бүхий хуулийн

[5] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
20 дугаар зүйл.**Зээлийн гэрээ**
20.1.Иргэний хуулийн 451.1-д заасны дагуу зээлийн гэрээгээр банк, эрх бүхий хуулийн этгээд нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь зээлийн гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, зээлийн гэрээнд заасан бол хүүг буцаан төлөх үүргийг хүлээнэ.
20.2.Зээлийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байна:
20.2.5.зээлийн гэрээний хугацаа.

СЗХ
2022 он 06 сар 08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03



этгээд энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу бичгээр гэрээ байгуулан данс нээсэн харилцагчид тухайн данстай холбоотой хадгаламж, шилжүүлэг, зээлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлж болно" гэж заасны дагуу ББСБ нь зээлдэгчтэй зээлийн гэрээг бичгээр байгуулснаар зээлийн үйлчилгээг цахимаар үзүүлэх боломжтой бөгөөд ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан хэрэглээний зээлийн эрхийн гэрээ нь бичгээр байгуулагдсан, талуудын гарын үсэг зурагдаж, тамга (тэмдэг) дарагдаж баталгаажуулсан байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт "энэ хуулийн 7.1-д заасны дагуу цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхэд нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, цахим гарын үсэг зэргийг ашиглаж болох бөгөөд эдгээрийг цахим хэлбэрээр хийсэн шилжүүлэг, зээлийн гэрээ, бусад хэлцэлд зурсан гарын үсэгтэй адилтгаж үзнэ", Хэрэглээний зээлийн эрхийн гэрээний 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтад[5] зээлдэгч нь гар утасны аппликейшнд нэвтрэх нэр, нууц үг, пин кодтой байна, Хэрэглээний зээлийн эрхийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.2 дахь заалтад "Зээлдэгч зээлийн нөхцөлтэй танилцаж хүлээн зөвшөөрснөө цахимаар баталгаажуулснаар цахим зээлийн гэрээг байгуулагдсанд тооцож, цахим зээлийн гэрээг зээлдэгчийн цахим хаягт хүргүүлэх ба зээлийн хөрөнгийг зээлдэгчийн дансанд шилжүүлнэ" гэж тус тус заасан байх тул талууд цахим зээлийн гэрээ байгуулахыг хүлээн зөвшөөрсөн байх бөгөөд цахим гэрээ нь дээр дурдсан хуулийн заалтад нийцсэн, хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй байна. ББСБ-ын зээлдэгчтэй байгуулж буй нийт сонгогдсон зээлийн дансдын хэрэглээний зээлийн эрхийн гэрээ болон түүний хүрээнд байгуулж буй цахим зээлийн гэрээ нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн заалтад нийцсэн, хүчин төгөлдөр байна гэж үзлээ.

ББСБ болон зээлдэгчийн хооронд байгуулсан хэрэглээний зээлийн эрхийн гэрээ болон цахим зээлийн гэрээний дагуу бусад этгээдэд давхар үүрэг хүлээгээгүй байх бөгөөд ББСБ-аас зээлийн дансдыг гуравдагч этгээдэд худалдах, бусдын өмнө үүрэг хүлээсэн аливаа хэлцэл (батлан даалт, барьцаа, баталгаа) хийсэн талаар нэмэлт мэдээлэл ирүүлээгүй болохыг дурдаж байна.

Иймд Хуулийн фирм нь сонгогдсон зээлийн дансдын зээл нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд зээлийн гэрээгээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад этгээдэд давхар үүрэг хүлээгээгүй байх шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

**Шалгуур 8. Зээлийн эргэн төлөлт нь бүрэн хорогдох байдлаар байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд ББСБ-ын зээлдэгчтэй байгуулсан хэрэглээний зээлийн эрхийн гэрээ болон цахим зээлийн гэрээ хуулиар тодорхойлсон хэлбэрийн шаардлага хангасан, хүчин төгөлдөр эсэх, хуульд заасан төлөөллийг хангасан эсэх, зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлийн хугацаанд зээл болон хүүг сар бүр тогтмол хэмжээтэйгээр төлөхөөр тусгасан эсэхийг шалгаж үзсэн бөгөөд улмаар нийт сонгогдсон зээлийн дансд нь тус шалгуурыг хангаж байна гэж дүгнэлээ.

**Шалгуур 9. Зээлдэгч эрх зүйн бүрэн чадамжтай, 18 нас хүрсэн, Монгол Улсын иргэн байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд зээлдэгчийн хувийн хэрэгт авагдсан зээлдэгчийн иргэний үнэмлэхний хуулбар, түүнд агуулагдсан иргэний төрсөн он, сар, өдөр, регистрийн дугаар,

---

[5] **Хэрэглээний зээлийн эрхийн гэрээ**
**4 дүгээр зүйл.** Зээлдэгчийн эрх, үүрэг
4.2.Зээлдэгч нь дараах үүрэгтэй. Үүнд:
4.2.6.Simple App ашиглахтай холбоотойгоор хүлээн зөвшөөрч баталгаажуулсан Үйлчилгээний үндсэн нөхцлийг бүрэн биелүүлж, нэвтрэх нэр, нууц үг, пин код, нэг удаагийн нууц үгийн нууцлалыг чандлан хадгалах, аливаа этгээдэд дамжуулахгүй байх,тэдгээрийг алдсан, бусад этгээд ашигласан байж болзошгүй тохиолдолд нэн даруй ББСБ-ын үйлчилгээний аль нэг сувгаар мэдэгдэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүйгээс үүрсан аливаа хохирлыг дангаар хариуцах;



УЛААНБААТАР
ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК

MANDAL CAPITAL MARKETS SC LLC

иргэншил, хаяг болон харилцагчийн зээлийн мэдээлэлд тусгагдсан зээлдэгчийн мэдээллийг нягталж үзлээ.

Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт[7] "иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно" гэж заасан. Иймд нийт шалгуулсан зээлийн дансдын зээлийн хувийн хэрэгт авагдсан баримт материалд үндэслэн тус шалгуурыг хангаж байна гэж дүгнэлээ.

**Шалгуур 10. Зээлдэгч нь сүүлийн 6 (зургаан) сар тасралтгүй ажил, хөдөлмөр эрхэлсэн байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь нийт сонгогдсон зээлийн дансдын зээлдэгчийн ажил эрхлэлтийн байдал, сүүлийн 6 (зургаан) сар тасралтгүй нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэхийг Хур систем-Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээлэл, зээлийн хувийн хэрэгт авагдсан харилцагчийн мэдээлэл, ББСБ-ын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй "ХУР системийн цалингийн мэдээллийг боловсруулах, Input Table утгажуулах аргачлал, логик, дагаж мөрдөх баримт бичиг"-ийн дагуу олгогдсон эсэхийг нягталж үзлээ.

Сонгогдсон зээлийн дансдын зээлийн хувийн хэргийн баримт материалд үндэслэн дүгнэж үзвэл нийт сонгогдсон зээлийн дансдын зээлдэгч нь сүүлийн 6 (зургаан) сар тасралтгүй ажил, хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байх тул нийт сонгогдсон зээлийн данс нь тус шалгуурыг хангаж байна гэж үзлээ.

**Шалгуур 11. Зээл олгох үед банк санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хуулийн фирм нь нийт сонгогдсон зээлийн дансдын зээл олгох үеийн зээлдэгчийн зээлийн үнэлгээний тайланд тусгагдсан нөхцөл шалгуур үзүүлэлтийн биелэлт, зээлийн лавлагаанд тусгагдсан мэдээлэл болон зээлийн түүхийн мэдээллийг нягталж үзлээ.

Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн 28 дугаар зүйлд[8] заасны дагуу банк бус санхүүгийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран Монголбанкны мэдээллийн санд ББСБ-ын өмнө хууль, гэрээгээр хүлээсэн зээлдэгчийн зээл, төлбөрийн талаарх зээлийн мэдээллийг тогтмол өгөх хуулийн зохицуулалттай байна. Иймд дүн шинжилгээнд хамрагдсан зээлийн дансдын зээлийн хувийн хэрэгт авагдсан зээл авах үеийн Монголбанкны ЗМС-ын мэдээлэл, баримт материалд үндэслэн тус шалгуурыг хангаж байна гэж дүгнэлээ.

---

[7] **Иргэний хууль (2002).**
**15 дугаар зүйл.sИргэний эрх зүйн бүрэн чадамж**
15.1.Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно.
15.2.Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүх 16-аас 18 хүртэлх насны иргэнийг, түүний хүсэлт, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлөөр иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцож болно.
15.3.Иргэний эрх зүйн бүрэн чадамжтай гэж тооцсон шүүхийн шийдвэрийг зохих үндэслэл байвал сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх хүчингүй болгож болно.
[8] **Зээлийн мэдээллийн тухай хууль (2011).**
**28 дугаар зүйл.Монголбанкны зээлийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох**
28.1.Монголбанк нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллага, зээлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага, төрийн байгууллага болон бусад аж ахуйн нэгжээс бүрдүүлсэн зээлийн мэдээллийн сантай байна.
28.2.Банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоо, санхүүгийн түрээс /лизинг/-ийн компани, төрийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс зөвшөөрөл авсан эсэхээс үл хамааран Монголбанкны мэдээллийн санд зээлийн мэдээллийг тогтмол өгнө.
28.3.Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй түүний бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргасан хүсэлтийг үндэслэн хууль болон гэрээний дагуу харилцан солилцоно.

НУУЦ БАРИМТ
**Эх хувь**

**Шалгуур 12. Зээлдэгч ипотекийн зээлтэй нөхцөлд татварын өмнөх орлогоос ӨОХ-г тооцох бөгөөд ӨОХ 60 (жаран) хувиас ихгүй, ипотекийн зээлгүй тохиолдолд татварын дараах орлогоос тооцож ӨОХ 80 (наян) хувиас ихгүй байх шалгуур үзүүлэлтийн дүгнэлт**

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс гаргаж өгсөн зээлдэгчийн өр, орлогын харьцаа үзүүлэлтэд үндэслэн зээлдэгч нь ипотекийн зээлтэй эсэх, зээлдэгчийн зээл авах үеийн зээл, төлбөрийн үүрэгтэй холбогдуулж авсан Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн зээлийн мэдээлэл, зээл авах үеийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг агуулсан ХУР төрийн мэдээлэл солилцооны системийн лавлагаа болон зээлдэгчийн зээл, үнэлгээний тайлан дахь өр, орлогын харьцаа болон зээлийн түүхийг нягталж шалгалаа. Мөн анхны үүрэг гүйцэтгүүлэгч ББСБ-ын сонгогдсон зээлийг өөрийн өрдийн практикт мөрдөгддөг бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, зээлийн үйл ажиллагааны ерөнхий журам, хэрэглээний зээлийн үйл ажиллагааны журмын дагуу олгосон эсэх, нотлох баримт бичгүүд нь ББСБ-ын хадгалалт, хамгаалалтад байгаа эсэхийг шалгалаа. Нийт шалгуулсан зээлийн дансаас тус шалгуур үзүүлэлтийг хангаагүй зээл сонгогдсон дансдын дундаас гараагүй болно.

**Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал**

Энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан гаргах өдрийн байдлаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 50 (тавин) зээлийн дансдаас зээлийн хөрөнгө болон зээлдэгдэгчид тавигдах хуулийн шаардлага хангаагүй, эрсдэлтэй гэж үзсэн зээлийн данс гараагүй гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

**Санал, зөвлөмж**

Хуулийн фирм нь Хөндлөнгийн дүн шинжилгээ хийх явцад цуглуулсан мэдээлэл дээрээ тулгуурлан цаашид хэрэглээний зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад хөрөнгө оруулагч, тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны эрсдэлийг бууруулахад дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Энэхүү санал, зөвлөмж нь зөвхөн цаашид анхаарч, судалж шийдвэрлэх нь зүйтэй гэсэн агуулгыг илэрхийлж буй бөгөөд аль ч тохиолдолд нэмэлт судалгаа, үнэлгээ, практик хэрэглээ, техник, эдийн засгийн боломж, үр дагаврыг сайн тооцоололгүйгээр шууд дамжуулах, заавал дагаж мөрдөхийг шаардах ёстой гэсэн санаа, зорилгоор бэлтгэгдээгүй болно.

Хуулийн фирм нь энэхүү хэсэгт дурдагдсан асуудлыг агуулсан зээлийн дансны хувийн хэрэг, түүнд агуулагдсан баримтыг "техникийн шинжтэй алдаа" гэж үзсэн тул эдгээр зөрчил, дутагдал илэрсэн зээлийн дансыг хуулийн шаардлага хангаагүй, эрсдэлтэй гэж үзээгүй болно.

Хэрэглээний зээлийн эрхийн гэрээний огноонд гараар засвар оруулсан болон огноо бичигдээгүй 2 (хоёр) тохиолдол гарсан. Хэрэглээний зээлийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт "Харилцагчийн төвийн ажилтан зээлийн гэрээг байгуулахдаа зээлийн гэрээнд зээл хүсэгчийн овог, нэр, регистрийн дугаарыг зөв бичсэн болон зээл хүсэгч өөрөө мөн эсэхийг иргэний үнэмлэх, гарын үсгийн маягттай нь тулган шалгаж баталгаажуулснаар зээлийн гэрээ байгуулсныг ипортал дээр тэмдэглэнэ" гэж заасны дагуу тухайн зээлдэгчийн хэрэглээний зээлийн гэрээг ипортал дээр тэмдэглэгдсэн өдрөөр шүүн шалгаж баталгаажуулсан. Хэдийгээр гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй боловч цаашид гэрээний огноог зөв, тодорхой тусгах нь зүйтэй гэж зөвлөж байна.

Хэрэглээний зээлийн үйл ажиллагааны журмын 9 дүгээр зүйлд "ББСБ-ын зээлийн хэвийн хэрэг нь (i) зээлдэгчийн мэдээлэл; (ii) зээлдэгчээс бүрдүүлсэн бүх бичиг баримт; (iii) зээлдэгчийн зээл үнэлгээний тайлан; (iv) зээлийн гэрээ; (v) зээлийн өргөдөл; (vi) зээл төлүүлэхтэй холбоотой хийгдсэн ажиллагаа, хийгдсэн ажиллагааны тайлан, тэмдэглэл, мэдэгдэл, шаардах хуудас, тэдгээрийн хувь; болон (vii) зээлийн хяналтын тайлан бүрдэнэ" гэж заасан. Хөндлөнгийн дүн

СЗХ
2022.06.08
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ-03

simple asset



шинжилгээний явцад зээлдэгчийн зээлийн хувийн хэрэгт зээл төлүүлэхтэй холбоотой хийгдсэн ажиллагаа, хийгдсэн ажиллагааны тайлан, тэмдэглэл, мэдэгдэл, шаардах хуудас, тэдгээрийн хувь болон зээлийн хяналтын тайлан хавсаргагдаагүй бөгөөд ББСБ-аас и-мэйлээр ирүүлсэн мэдээллээр цахим зээл олголт хийгдэх үед зээлдэгчийн цахим хувийн хэрэгт (i) зээл хүссэн өргөдөл; (ii) зээлийн үнэлгээний тайлан; (iii) зээлдэгчийн мэдээлэл; болон (iv) цахим зээлийн гэрээ үүсгэж хадгалдаг тухай тодруулга ирүүлсэн. Иймд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь холбогдох дүрэм, журамд зээлдэгчийн хувийн хэргийн бүрдлийг тодорхой тусгах, зээлийн хяналтын тайланг зээл тус бүр үйлдэж ажиллах болон зээлийн хувийн хэргийн бүрдлийг бүрэн хангаж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.

Хэдийгээр энд дурдсан үйл баримт нь холбогдох гэрээ, баримт материалын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй боловч цаашид үйл ажиллагаандаа анхаарч нэг мөр болгох нь зүйтэй гэж Хуулийн фирмээс үзэж байна.

**Хариуцлага хязгаарлах тухай**

Хуулийн фирмийн Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан нь энд тусгайлан дурдсан шалгуур асуудлуудыг хамарсан болохыг анхаарна уу.

Энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан нь хөндлөнгийн, хараат бус дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд заавал дагаж мөрдөх, мөрдөхийг шаардах эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлсэнд тооцогдохгүй. Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан нь хөрөнгийн нийт багцад хөрөнгө оруулалт хийхийг зөвлөсөн, санал болгосон шинжийг агуулаагүй бөгөөд Хуулийн фирмд хөрөнгө оруулагчийн зүгээс санхүүгийн болон аливаа хуулийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

Эрх олгогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайланг бүхэлд нь болон хэсэгчлэн салган авч ашиглах, түгээх, дамжуулах, Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлгүйгээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бусдад санал болгохыг хориглоно.

Энэхүү Хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцад гаргасан баталгаанд тооцогдохгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ХУЛАН

БАТБААТАР ЭНД ПАРТНЕРС ХХН

УЛААНБААТАР ХОТ
ӨЛЗИЙТ ИНВЕСТ КО КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
СИМПЛ АССЕТ ХХК



MANDAL CAPITAL MARKETS LLC

СЗХ
2022.06.08 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2022-06-16

**Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл үнэн зөв болохыг батлав:**

| | |
|---|---|
| *1. Овог, нэр:Д. Баярсайхан*<br><br>*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Симпл ассет"ХХК-ийн ТУЗ-ийн дарга*<br><br>*Гарын үсэг:………………………………*<br><br>*(Тамга/тэмдэг)* | *4 . Овог, нэр: Б.Билигүүн*<br><br>*Албан тушаал: Үүсгэн байгуулагч "Ашид капитал ББСБ"ХХК-ийн ТУЗ-н дарга*<br><br>*Гарын үсэг:………………………………*<br><br>*(Тамга/тэмдэг)* |
| *2. Овог, нэр:Э. Сэлэнгэ*<br><br>*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Симпл ассет"ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн*<br><br>*Гарын үсэг:………………………………*<br><br>*(Тамга/тэмдэг)* | *5. Овог, нэр:Б. Өлзийбаяр*<br><br>*Албан тушаал: Андеррайтерийн "Өлзий энд Ко капитал ҮЦК"ХХК -ийн Гүйцэтгэх захирал*<br><br>*Гарын үсэг:………………………………*<br><br>*(Тамга/тэмдэг)* |
| *3. Овог, нэр:Б. Тэмүүлэн*<br><br>*Албан тушаал: Үнэт цаас гаргагч "Симпл ассет"ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн*<br><br>*Гарын үсэг:………………………………*<br><br>*(Тамга/тэмдэг)* | *6. Овог, нэр: Б.Батхишиг*<br><br>*Албан тушаал: Андеррайтерийн "Мандал капитал маркетс ҮЦК"ХХК -ийн Гүйцэтгэх захирал*<br><br>*Гарын үсэг:………………………………*<br><br>*(Тамга/тэмдэг)* |